


НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

MANDAL  
ASSET  
MANAGEMENT

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН



2021 -06- 25

# ХӨРӨНГӨ БҮРТГЭВ-03 ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД



"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын хөрөнгө оруулалтын сан (цаашид "Сан" гэх) нь Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн холбогдох журмуудын дагуу нэгж эрхээ олон нийтэд нээлттэй санал болгож байна.

Энэхүү Сангийн нэгж эрхийн танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангахад анхаарч ажилласан ба холбогдох дүрэм, журмаар шаардагдах мэдээллүүдийг бүрэн агуулахыг зорьсон болно.

Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг "Монголын хөрөнгийн бирж" төхөк бүртгэсэн нь уг нэгж эрхийн эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааны түүхэн гүйцэтгэл нь энэхүү нэгж эрхийг гаргаж буй сангийн ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй. Энэхүү нэгж эрхийг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ямагт эрсдэлтэй үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, нэгж эрхийн танилцуулга, нэгж эрх гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Энэхүү нэгж эрхийн танилцуулгад тусгагдсан мэдээллийн талаар илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл авах, лавлаж тодруулахыг хүсвэл Сангийн хөрөнгө оруулалтын менежментийн компани болох "Мандал Ассет Менежмент УЦК" ХХК-д хандана уу.

Түүнчлэн, өөрийн үнэт цаасны брокер, санхүү, хууль зүй эсхүл хөрөнгө оруулалтын зөвлөхтэйгээ холбогдохыг зөвлөж байна.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
САНГИЙН НЭГЖ ЭРХТ АРГАХАД ОРОЛЦОН  
БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ:  
**БҮРТГЭВ-03**

Хөрөнгө оруулалтын менежментийн компани

MANDAL  
ASSET  
MANAGEMENT



"Мандал Ассет Менежмент УЦК" ХХК

Регистрийн дугаар: 5497418

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян-  
Гүний гудамж, Меру тауэр-602 тоот

Утас: +976-7272 9911

И-мэйл: support@mandalasset.mn

Хуулийн фирм:

**DB&GTS**

Өмгөөллийн "ДиБи энд ЖиTiЭс" ХХН

Регистрийн дугаар: 6387942

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Чингисийн  
өргөн чөлөө-24, 705 тоот

Утас: +976 1133-1020

И-мэйл: info@dblaw.mn

Кастодиан

**ГОЛОМТ БАНК**  
Сийн шийн болон санхүүгийн з

"Голомт Банк" ХХК

Регистрийн дугаар: 2075377

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,  
Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо,  
Сүхбаатарын, 5, Голомт банк төв байр

Утас: +976 7011-1646

И-мэйл: mail@golomtbank.com



# АГУУЛГА

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021 -06- 25

БҮРТГЭВ-03

ХУСНЭГТ  
ЗУРАГ

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР  
ТОВЧИЛСОН УГИЙН ТАЙЛБАР



6  
6  
7  
9

1	"МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ" ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
2	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТУХАЙ</b>	11
2.1	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ	11
2.2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД	13
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ БОЛОН БҮТЭЦ	16
2.4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЗАРДАЛ	17
2.5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	18
2.6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ	20
2.7	ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН	21
2.8	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН	22
2.8.1	Гадаад зах зээл	22
2.8.2	Дотоод зах зээл	23
2.8.3	Хөрөнгийн зах зээлийн нехцөл байдал	28
2.8.4	Хөрөнгийн биржийн арилжааны тухай	30
3	<b>"МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ" ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА</b>	30
3.1	ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	30
3.2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО	31
3.2.1	Нээлттэй өмчлөлийн хэрэгсэлд хөрөнгө оруулах стратеги	32
3.2.2	Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах стратеги	33
3.2.3	Хөрөнгө оруулалтын хэрэгслийн хязгаарлалт	33
3.2.4	Хөрөнгө оруулалтын судалгаа	33
3.3	УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	34
3.3.1	Сангийн үйл ажиллагааны схем	34
3.3.2	Нэгж эрх эзэмшигчдийн хурал	34
3.3.3	Төлөөлөн удирдах зөвлөл	35
3.3.3.1	Дотоод хяналтын хороо	38
3.3.4	Гүйцэтгэх удирдлага	38
3.3.5	Сангийн бүтэц, зохион байгуулалтад оролцогч бусад талууд	40
3.3.5.1	Кастодиан	40
3.3.5.2	Эрх бүхий байгууллага	41
3.4	ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА БАРИМТЛАХ БОДЛОГО	41
3.4.1	Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	41
3.4.2	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай	41
3.4.3	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай	41
3.5	НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО	41
3.6	ТАТАН БУУГДАХ ТОХИОЛДОЛД ОРЛОГО ХУВААРИЛАХ БОДЛОГО	42
3.7	САНГИЙН ЗАРДАЛ	43
3.8	ТАТВАР	44
3.9	САНД ХӨРӨНГӨ ТАТАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	44
3.10	САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	44
4	<b>"МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ" ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА</b>	47
4.1	НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ	47



**5 "МАНДАЛ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК" ХХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА**

- 5.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- 5.2 УДИРДЛАГА, КОМПАНИЙН БҮТЭЦ
- 5.3 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
- 5.4 ДОТООД ХЯНАЛТЫН АЛБА
- 5.5 МЕНЕЖМЕНТИЙН БАГ

49  
50  
51  
52  
53

**6 ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ**

- 6.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРСДЭЛ
- 6.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ
- 6.3 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРСДЭЛ

54  
56  
58  
59

**7 ХАВСРАЛТ**

61

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1.	Европын холбооны улсууд болон АНУ дахь зохицуулалтын ялгаа	12
Хүснэгт 2.	Хөрөнгө оруулалтын сангийн төрлүүд	13
Хүснэгт 3.	Хувьсах болон уламжлалт Хөрөнгө оруулалтын сангийн харьцуулалт	15
Хүснэгт 4.	Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой зардал	17
Хүснэгт 5.	Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааны загвар	20
Хүснэгт 6.	Активын хөрөнгөөр тэргүүлэгч топ 5 компани	20
Хүснэгт 7.	Түүхий эдийн үнийн таамаглал, ам.доллар	23
Хүснэгт 8.	Эдийн засгийн ёсөлтийн гүйцэтгэл, салбаруудаар, хувиар	24
Хүснэгт 9.	Эдийн засгийн ёсөлтийн таамаглал, салбаруудаар, хувиар	26
Хүснэгт 10.	Инфляц болон ханшийн таамаглал, хувиар	27
Хүснэгт 11.	Хөрөнгө оруулалтын багцын төлөвлөгөө	32
Хүснэгт 12.	Зардлын бүтэц	43
Хүснэгт 13.	Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл /сая.төг/	45
Хүснэгт 14.	Орлогын дэлгэрэнгүй тайлангийн төсөөлөл /сая.төг/	46

## ЗУРАГ

Зураг 1.	Хөрөнгө оруулалтын сангийн үүсэл хөгжил	12
Зураг 2.	Хөрөнгө оруулалтын сан (ХОС)-ийн бүтэц	17
Зураг 3.	Хөрөнгө оруулалтын сангийн зах зээл, бүс нутгаар, 2020	18
Зураг 4.	Хөрөнгө оруулалтын сангийн төрлөөр, 2020	18
Зураг 5.	Дэлхийн хөрөнгө оруулалтын сангудын удирдаж буй нийт хөрөнгө, их наяд ам.доллар	18
Зураг 6.	Хөрөнгө оруулалтын сангийн удирдаж буй нийт хөрөнгө, бүс нутгаар	19
Зураг 7.	"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК, ТОП 20 индекс	29
Зураг 8.	Монголын арилжааны банкнуудын өөрийн хөрөнгө	29
Зураг 9.	Сангийн үйл ажиллагаа	34
Зураг 10.	"Мандал Ассет Менежмент УЦК" ХХК-ийн бүтэц	50
Зураг 11.	Эрсдэлийн удирдлагын бүтэц	55
Зураг 12.	Эрсдэлийн удирдлагын тогтолцоо	56

2021 -06- 25

БҮРТГЭВ-03

СЭХ  
2021 -06- 25. өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

# НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

## “Брокер”

Харилцагчийн хөрөнгөөр, түүний нэрийн өмнөөс, түүний даалгавраар үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэхийг үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэгч;

## “Дилер”

Өөрийн нэрийн өмнөөс өөрийн хөрөнгөөр үнэт цаасыг худалдах, худалдан авах ажиллагааг үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэгч;

## “Кастодиан”

Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг тухайн сангийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгөөс тусгаарлан хадгалж, төлбөр, тооцоог гүйцэтгэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хөрөнгө оруулалтын сангийн гишүүдэд холбогдох мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээг хууль болон хөрөнгө хадгалах гэрээний хүрээнд үзүүлэх кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээдийг;

## “Ногдол ашиг”

Жил бүрийн нашгийн хуваарилалтюм. Түүний хэмжээг хувьцаа эзэмшигчийн хурлаар шийдвэрлэдэг;

## “Нэгж эрх”

Хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулалтын санд оруулсан хөрөнгийг өмчлөх эрхийг гэрчлэх нэрийн үнэт цаасыг;

## “Нэгж эрхийн танилцуулга”

Хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдан авах саналыг хүргүүлэхтэй холбоотой, уг санг үүсгэн байгуулагчаас энэ хуульд заасан журмын дагуу бэлтгэсэн баримт бичгийн бурдлийг;

## “Нэгж эрх эзэмшигч”

Тухайн хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулж сангийн нэгж эрхийг эзэмшигч иргэн, хуулийн этгээдийг;



2021 -06- 25

**БҮРТГЭВ-02**

**“Нэгж эрх  
эзэмшигчдийн хурал”**

Хөрөнгө оруулалтын сангийн эрх барих  
байгууллагыг;

**“Нэрлэсэн үнэ”**

Хөрөнгө оруулалтын сангийн дүрмээр тогтоосон  
нэрлэсэн үнийг;

**“Өрийн хэрэгсэл”**

Үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаа дуусмагц  
үндсэн төлбөр болон хүүг мөнгөн хэлбэрээр,  
эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн  
хэлбэрээр тухайн үнэт цаасыг эзэмшигчид эргүүлэн  
төлөх үүргийг гэрчилсэн болон түүнтэй адилтгах  
бусад үнэт цаасыг;

**“Хөрөнгө оруулалтын  
сан”**

Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн  
удирдлагаар мэргэжлийн хөрөнгө оруулалтын  
үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл  
хаалттай хүрээнд төвлөрүүлсэн хөрөнгийн санг;

**“Хамтын хөрөнгө  
оруулалтын сан”**

Нэгж эрхээ Санхүүгийн Зохицуулах Хорооноос  
тогтоосон журмын дагуу үнэт цаасаа 50-аас дээш  
тооны этгээдэд санал болгон худалдахаа мэдээллийн  
хэрэгслээр нийтэд мэдэгдэж нийтэд санал болгох  
замаар мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх эрх бүхий  
хөрөнгө оруулалтын санг;

**“Хувийн хөрөнгө  
оруулалтын сан”**

Нэгж эрхээ мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл  
ажиллагаа эрхлэгчийн хүрээнд санал болгон  
гэрээний үндсэн дээр хөрөнгө төвлөрүүлэх эрх  
бүхий хөрөнгө оруулалтын санг;

**“Хөрөнгө оруулалтын  
сангийн зардал”**

Хөрөнгө оруулалтын санд бусдаас үзүүлэх хөрөнгө  
итгэмжлэн удирдах, кастодиан, брокер, няглан  
бодох бүртгэлийн зэрэг үйлчилгээний нийт  
төлбөрийг;

**“Хөрөнгө оруулалтын  
хэрэгсэл”**

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон энэ  
хуулийн хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хорооноос  
тогтоосон бөгөөд тухайн хөрөнгө оруулалтын  
сангийн хөрөнгө оруулалтын бодлогод заасан,  
хөрөнгө оруулалтхийж болох санхүүгийн хэрэгслийг;

**“Хөрөнгө оруулалтын  
менежментийн  
компани”**

Хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний  
дагуу түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж  
байгаа тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах  
зээлийн зохицуулалттай хуулийн этгээдийг;




2021 -06- 25

"Хөрөнгийн бирж"

БҮНТ ЦААСЫН 02

Унэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа эрхлэх 01



"Хөрөнгө оруулалтын сангийн цэвэр актив"

Хөрөнгө оруулалтын сангийн цэвэр актив" гэж хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгийн дунгээс өр төлбөрийг хасаад үлдсэн хөрөнгийг

"Санхүүгийн хэрэгсэл"

Унэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, мөнгөний болон зохицуулалттай зах зээлд арилжихыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслийг;

"Сангийн менежер"

Хөрөнгө оруулалтын менежментийн компаниас томилогдсон хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлагыг;

"Төлөөлөн удирдах зөвлөл"

Хөрөнгө оруулалтын санг удирдлагаар хангаж, стратеги, хэтийн төлөвийг тодорхойлох, Нэгж эрх эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх байгууллагыг;

"Унэт цаас гаргагч"

Унэт цаасны зах зээлд арилжих унэт цаасаа Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа этгээдийг.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>ОУВС</b>	Олон Улсын Валютын Сан
<b>Сан</b>	"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын хөрөнгө оруулалтын сан
<b>ТӨХК</b>	Төрийн өмчит хувьцаат компани
<b>ТУЗ</b>	Төлөөлөн удирдах зөвлөл
<b>ХК</b>	Хувьцаат компани
<b>ХОМК</b>	"Мандал Ассет Менежмент ҮЦК" ХХК
<b>IPO</b>	Initial public offering буюу хувьцааг олон нийтэд санал болгох замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх



**1 “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ” ХАМТЫН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ  
ЭРХИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

СЭХ  
он... сар...адар  
Б 2021, 06, 23  
№ 01

Сан нь Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн холбогдох журмуудын дагуу нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000,000 ширхэг хүртэлх нэгж эрх гаргаж, үүний 95 хувь буюу 47,500,000 ширхэг хүртэлх нэгж эрхийг олон нийтэд санал болгон арилжаална.

<b>Хөрөнгө итгэмжлэн удирдах компани</b>	“Мандал Ассет Менежмент УЦК” ХХК
<b>Сангийн нэр</b>	“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын хөрөнгө оруулалтын сан
<b>Сангийн хэлбэр</b>	Хамтын
<b>Сангийн төрөл</b>	Хаалттай
<b>Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа</b>	10 жил
<b>Татан төвлөрүүлэх нийт хөрөнгийн дүн</b>	50 тэрбум төгрөг хүртэлх
<b>Сангийн удирдлага</b>	Нэгж эрх эзэмшигчдийн хурал
<b>Олон нийтэд санал болгох нэгж эрхийн тоо</b>	47,500,000 ширхэг хүртэлх
<b>Санал болгох хүрээ</b>	Олон нийт
<b>Шимтгэлийн бүтэц</b>	Удирдаж буй хөрөнгийн хэмжээнээс (AUM): 1%  Цэвэр хөрөнгийн үнэлгээний (NAV) өсөлт: 10%
<b>Хөрөнгө оруулалтын багц</b>	Хувьцаа, тогтмол орлоготой үнэт цаас, бусад
<b>Хөрөнгө итгэмжлэн хадгалах</b>	“Голомт Банк” ХХК – Кастодиан банкны хэлтэс
<b>Хөрөнгө хэлбэр</b>	Монголын хөрөнгийн биржийн хоёр дахь зах зээлийн арилжаа
<b>Нэгж эрхийн үнэ тогтох хэлбэр</b>	Хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV) дээр үндэслэгдэн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр тогтоно
<b>Арилжааг зохион байгуулах байгууллага</b>	“Монголын Хөрөнгийн Бирж” СААД УЛААНбаатар хот



## 2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТУХАЙ

### 2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

#### БҮРТГЭВ-03





Анхны хөрөнгө оруулалтын сан (өнөөгийн хамтын сан) нь 1772-1773 онд Нидерланд Улсын Амстердам хотод үүссэн гэж үздэг бөгөөд худалдаачин Абрахам Ван Кэтвич "Eendragt Maakt Magt" гэсэн нэр бүхий итгэлцэлд суурилсан санг анх үүсгэн байгуулжээ. Тус сангийн нэрийг Монгол хэлнээ буулгавал "олны хүч оломгүй далай" гэсэнтэй утга дүйх юм. Сан нь иргэд, жижиг хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татан төвлөрүүлж ашигтай бонд болон бусад санхүүгийн хэрэгслүүдэд жигд тархаан байршуулж хөрөнгө оруулалт хийж эхэлжээ. Ийнхүү хамтын хөрөнгө оруулалтын сан үүссэнээр иргэдийн хувьд хөрөнгийн хэмжээ бага байсан ч багцаа төрөлжүүлж өндөр өгөөж хүртэх боломжтой болсон юм.

Үүнээс хойш 1868 онд Их Британид, 1893 онд АНУ-д дээрхийн адил сангуд үүсч хөгжижээ. Мөн 1924 онд хамгийн анхны нээлттэй хамтын буюу нэгж эрхээ олон нийтэд санал болгох боломжтой "Массачусетсийн хөрөнгө оруулалтын сан" байгуулагдаж амжилттай хөрөнгө оруулалтууд хийсэн байна. Энэхүү Массачусетсийн хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын компанийн үндсийг тавьж цаашдын хөгжилд чухал суурь болсон гэж үздэг. Жишээлбэл: Хөрөнгө оруулалтын сан хаагдах хугацаа дуустал хөрөнгө оруулалтаа татах боломжгүй байсныг хувьцаа болгон шилжүүлж хөрөнгө оруулалтаа буцаан татах ба нэмж хөрөнгө оруулалт хийх зэргийг нээлттэй болгосон байна.

1929 онд тохиосон их хямралын дараагаар хамтын хөрөнгө оруулалтын сангийн хууль, журмууд илүү боловсронгуй болж, 1940 онд АНУ-ын "Хөрөнгө оруулалтын компанийн тухай" хууль батлагдсан нь хөрөнгө оруулалтын сангийн цаашдын хөгжилд гол тулгуур болсон аж. Хөрөнгө оруулалтын компани нь ихэнхдээ корпораци, итгэлцэл, нөхөрлөл, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдах бөгөөд энэ нь үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг компани юм. 1934 онд АНУ-д "Үнэт цаас, биржийн хороо" (SEC) байгуулагдаж хөрөнгө оруулалтын сангудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах болсон нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чухал алхам болсон байна.

АНУ-ын хамтын хөрөнгө оруулалтын сангийн салбар нь хөрөнгийн зах зээлд итгэх итгэл эргэж сэргэх хугацаа буюу 1950 он хүртэл хязгаарлагдмал байв. 1960 онд Бостоны Фиделити (Fidelity) сан нь хөрөнгө чинээтэй хүмүүс болон санхүүгийн салбарын хүмүүсээс илүүтэйгээр олон нийт, иргэдэд зориулсан хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг эхлүүлсэн.





Мөн 1970 оноос мөнгөний зах зээл дэх өндөр өгөөжтэй санхүүгийн хэрэгслүүд гарч эхэлсэн нь тус салбарыг идэвхжүүлж, 1976 онд индексэд сууринласан сан болох Вангуард Групп “Вангуард Групп” байгуулдсан бөгөөд одоогоор дэлхийн хамгийн том хамтын хөрөнгө оруулалтын санд тооцогддог. Үүнээс хойш өнөөг хүртэл дэлхий дахинд хамтын хөрөнгө оруулалтын сангүүд маш хурдтайгаар хөгжиж ирсэн бөгөөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн гэж үздэг. Үүнд:

- Хувьцаа болон бондын үнийн өсөлт;
- Санхүүгийн шинэ бүтээгдэхүүнүүд (засгийн газар болон хотын бонд, салбар болон олон улсын зах зээлд төвлөрсөн сангүүд гэх мэт);
- Хөрөнгө оруулалтын сангүүдыг тэтгэврийн системтэй уялдуулсан явдал.

Дэлхий дахинд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаагаар АНУ тэргүүлж, Европын Холбооны улсууд удаалж байна. Тус хоёр зах зээлийн зохицуулалтын ялгааг доорх хүснэгтэд харьцуулан харуулав:

Хүснэгт 1. Европын холбооны улсууд болон АНУ дахь зохицуулалтын алгаа

Европын холбоо /UCITS/	АНУ /Open-ended mutual fund/
Хууль, эрх зүйн гол баримт бичиг	UCITS удирдамж
Зохицуулах байгууллага	Улс бүрийн зохицуулах байгууллага
Хараат бус ТУЗ	Шаардлагагүй
Цэвэр хөрөнгийн үнэлгээ /NAV/	Сард хамгийн багадаа 2 удаа
Хөрөнгө удирдлагын гэрээ	Шаардлагатай тохиолдолд шинэчилнэ
Хөрөнгө оруулалтын хөрвөх чадвар	Нийт активын 10-аас дээшгүй хувийг зохицуулалтгүй зах зээлд арилжаалагддаг үнэт цаасанд оруулж болно
Татварын орчин	Татваргүй, бүртгэлийн хураамж телне
Үйлчилгээ үзүүлэгч этгээд	Менежментийн компани, хадгаламжийн байгууллага, шилжүүлгийн агент, бүртгэгч, аудитор, төлбөр гүйцэтгэх байгууллага
Зээл/санхүүгийн хөшүүргийн хязгаарлалт	Богино хугацаанд 10%-иас дээшгүй
	Банкны зээл/санхүүгийн хөшүүргийн хязгаарлалт
	УДААНЫ МАТАР ХОТ МАНДАЛ ИРЭЭДҮҮН ӨСӨЛТ ХАМТЫН АОС ХХК Г.Ганзориг 9021060636 д. 6702088

**2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД**

2021 -06- 25

Хөрөнгө оруулалтын сан нь  
**БҮРТГЭВ-03**  
эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх замаар нийтээс татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг өөрийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн түвшинд үр ашигтай хөрөнгө оруулалт хийх замаар үнэт цаасны зах зээлээс олсон өгөөжийг хөрөнгө оруулагчдадаа (нэгж эрх эзэмшигч) хүртээх зорилго бүхий мэргэжлийн хөрөнгө оруулалтын хуулийн этгээд юм. Хөрөнгө оруулалтын санг үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болох хөрөнгө оруулалтын менежментийн компани гэрээний үндсэн дээр хууль тогтоомж болон хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгасан стратегийн дагуу удирдан, зохион байгуулдаг. Харин хөрөнгө оруулагчид нь хөрөнгө оруулалтын сангийн бүтэц, хөрөнгө оруулалтын хэлбэр, түүний хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, нэгж эрхийн танилцуулга зэрэгт судалгаа хийсний үндсэн дээр тухайн хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг гаргадаг.

Олон улсын хэмжээнд болон Монгол Улсад хамтын хөрөнгө оруулалтын санг хаалттай болон нээлттэй гэсэн хоёр төрөлд хуваадаг. Нээлттэй хамтын хөрөнгө оруулалтын сан нь үнэт цаасаа бусдад худалдахаар тогтмол санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг бөгөөд


үнэт цаасаа эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг бол хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан нь үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд нэгж эрхээ санал болго замаар үнэт цаас гаргаж, нэгж эрхийн нэрлэсэн үнээр худалддаг, гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй онцлогтой байдаг. Хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулагчдаас тодорхой хугацаагаар эх үүсвэрийг татан, хөрөнгө оруулалт хийх боловч хөрөнгө оруулагчдаас нэгж эрхийг буцаан худалдан авах үүргийг хүлээдэггүй тул хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа сангаас гаргах нөхцөлд сангийн нэгж эрхээ гуравдагч этгээдэд л худалдаалах боломжтой байдаг. Харин нээлттэй хамтын хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулагчдад хүссэн үедээ хөрөнгө оруулалт хийж, шаардлагатай нөхцөлд сангийн нэгж эрхээ буцаан санд худалдаалах замаар хөрөнгө оруулалтаа гаргах авах боломжийг олгодог.

Мөн хөрөнгийн зах зээл болон сангийн үйлажиллагааг дэмжсэн байдлаар хөрөнгийн биржээр арилжаалагдах сан (ETF) болон хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулагч сан (Fund of fund) зэрэг төрлүүд байдаг. Эдгээр төрлийн хөрөнгө оруулалтын сангудын гол ялгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын сангийн төрлүүлэл

Хаалттай сан	Нээлттэй сан	Биржээр арилжаалагддаг сан /ETF/
Нэгж эрхийн тоо	Тогтмол	Хөвөгч
Үнэлгээ	Зах зээлийн үнэ	Өдөр бүр "Цэвэр хөрөнгийн үнэлгээ"-г хийдэг /Daily Net Asset Value/
Багцын мэдээлэл	Сар эсвэл улирлаар	Сар эсвэл улирлаар
Хөрөнгө чадвар	Хөрөнгийн бирж дээр гуравдагч этгээдэд арилжаалах	Өдрийн эцсийн үнэлгээгээр сангаас буцаалт хийх боломжтой
Нэршил	АНУ ИБУИНВУ Европ	Closed end fund Investment Trust SICAF
		Mutual Fund Unit Trust SICAV





СЭХ

2021 169 23 өдөр

Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулах арга хэрэгсэл болон тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, эсхүл хувьцааг хөрөнгө оруулагчдад хэрхэн санал болгож байгаагаас хамааран өөр өөр нэршилтэй байж болно. Тухайлбал: олон улсад хедж сан (hedge fund) нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлж, уламжлалт бус хөрөнгө оруулалтын стратеги ашиглан эрсдэл өндөртэй, санхүүгийн хөшүүрэгтэй хэрэгсэлд хөрөнгө оруулдаг, нэгжэрхэсхүлхувьцаагтодорхой хязгаарлалтын хүрээнд буцаан худалдах боломжтой сан юм. Харин хувийн хөрөнгө оруулалтын сан (private equity) нь 10 хүртэлх жилийн хугацаатай хаалттай сан бөгөөд хөрөнгө оруулагч нэгж эрх, хувьцаагаа санд буцаан худалдах эрхгүй, тодорхой хугацааны дараа сангийн активыг худалдах, эсхүл эерэг мөнгөн урсгал олох тохиолдолд ашгаас хувь хүртдэг сан болно.

**ДЭЛХИЙН УЛСОРНИУДАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН НЬ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ,  
ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧНООС ХАМААРАН БУТЦИЙН ХУВЬД ХАРИЛЦАН АДИЛГҮЙ  
БАЙХ БОЛОВЧ НИЙТЛЭГ ШИНЖИЙН ХУВЬД ДАРААХ БУТЦЭД АНГИЛАГДДАГ. ҮҮНД:**

Хүснэгт 3 Хувьсах болон уламжлалт Хөрөнгө оруулалтын сангийн харьцуулалт

	Хувьсах /alternative/ хөрөнгө оруулалт	Уламжлалт хөрөнгө оруулалт	
	Хаалттай сан	Нээлттэй сан	Нээлттэй сан
<b>Хөрөнгө оруулалтын хэлбэр</b>	<ul style="list-style-type: none"> <li>Хувийн хөрөнгө оруулалтын сан /Private equity/</li> <li>Венчур капитал /Venture capital/</li> <li>Дэд бүтэц /Infrastructure/</li> <li>Гарааны бизнес хөрөнгө оруулагч сан /Angel fund/</li> <li>Үл хөдлөх хөрөнгө /Real estate/</li> <li>Хувийн хөрөнгө худалдан авалт /Private equity Buy-out/</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хедж сан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хувьцаа</li> <li>Засгийн газар, компанийн бонд</li> <li>Мөнгөн хөрөнгө</li> </ul>
<b>Шимтгэл</b>	<ul style="list-style-type: none"> <li>Менежментийн төлбөр</li> <li>Гүйцэтгэлийн төлбөр + босго өгөөжийн хувь</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Менежментийн төлбөр</li> <li>Гүйцэтгэлийн төлбөр + босго өгөөжийн хувь</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Менежментийн төлбөр</li> </ul>
<b>Хөрөнгө оруулалтын хугацаа</b>	Ихэвчлэн 10-12 жил	18 сар хүртэл	Хэдэн өдрөөс хэдэн жил
<b>Хөрөнгө оруулалтын хамрах хүрээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>Уян хатан хөрөнгө оруулалтын бодлого</li> <li>Хугацааны эцэст нийт хөрөнгө оруулалт буцаан хуваарилагддаг, хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг</li> <li>Өр төлбөр, үсмэл санхүүгийн хэрэгсэл ашиглах боломжтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Уян хатан</li> <li>Хөрвөх чадвар мую байж болно</li> <li>Өр төлбөр, үсмэл санхүүгийн хэрэгсэл ашиглах боломжтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хязгаарлагдмал</li> <li>Хөрвөх чадвартай, үнэт цаас худалдан авах</li> <li>Өр төлбөрийг ашиглах байдал хязгаарлагдмал</li> </ul>
<b>Мөнгөн хөрөнгийн ургал</b>	Мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулах болон хөрөнгө оруулагчдад буцаан олгох хугацааг таамаглах боломжгүй	Мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулах, буцаан олгох хугацааг таамаглах харьцангуй боломжтой	Мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулах, буцаан олгох хугацааг таамаглах харьцангуй боломжтой
<b>Хөрвөх чадварын хязгаарлалт</b>	<ul style="list-style-type: none"> <li>Сан нь нэгж эрхийг буцаан худалдан авах үүрэг хүлээдэггүй</li> <li>Хоёрдогч зах зээлд арилжих болно</li> </ul>	Хөрөнгө буцаан татах хугацаа удаан, хойшлогдох боломжтой	<ul style="list-style-type: none"> <li>Богино хугацаанд хөрөнгөө буцаан татах боломжтой</li> </ul>
<b>Хөрөнгө оруулагчийн хязгаарлалт</b>	Зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагч, эсхүл өндөр орлоготой этгээд	Зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагч, эсхүл өндөр орлоготой этгээд	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжлийн хөрөнгө оруулагч</li> <li>Аливаа этгээд</li> </ul>
<b>Гүйцэтгэл</b>	Мөнгөн хөрөнгийн дундаж өгөөжийн хувьд сууринсан	Мөнгөн хөрөнгийн дундаж өгөөжийн хувьд сууринсан	<ul style="list-style-type: none"> <li>Цаг хугацаанд сууринсан</li> </ul>

Энэ сурвалж: Дэлжийн эдинийн



## 2.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ БОЛОН БҮТЭЦ

**БҮРТГЭВ-03**

Хөрөнгө оруулалтын сан нь дараах хоёр хэлбэртэй байдаг. Үүнд:

- **Хамтын хөрөнгө оруулалтын сан:**

Хамтын хөрөнгө оруулалтын сан нь олон нийтээс мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлж, нийтэд мэдээлсэн бодлогын баримт бичгийн дагуу хувьцаа, өрийн хэрэгсэл болон Засгийн газрын үнэт цаас зэрэгт хөрөнгө оруулдаг. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь дотроо дараах төрөлтэй байдаг. Үүнд:

- **Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан**
- **Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан.**

Хамтын хөрөнгө оруулалтын сан нь дээр дурдсанчлан тогтмол эсхүл хөвөгч нэгж эрхийн тоо ба хөрөнгө оруулагчид нэгж эрхээ санд буцаан худалдах авах эрхтэй, эрхгүй эсэхээс шалтгаалан хаалттай болон нээлттэй гэж ангилагддаг. Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан нь үнэт цаасаа бусдад худалдахаар байнга олон нийтэд санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг бөгөөд үнэт цаасаа эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг. Ингэхдээ хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлого, зорилго, холбогдох эрсдэлүүд, сангийн үйл ажиллагааны зардал, төлбөр, гүйцэтгэлийн хувь, хөрөнгө оруулалтын зөвлөхийн талаар дэлгэрэнгүй мэдээлнэ. Харин хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан нь үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр үнэт цаас гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй

- **Хувийн хөрөнгө оруулалтын сан:**

Цөөн тооны буюу хөрөнгө мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татан төвлөрүүлж, тус хөрөнгөө санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг төрлийн сан юм.

Олон улсын жишгээр олон нийтэд нээлттэй арилжаалдаг хөрөнгө оруулалтын сан нь бүтэц, засаглалын хувьд гэрээний загвар болон компанийн загвар гэсэн 2 бүтэцтэй байна. Үүнд:

- **Компанийн бүтэцтэй хөрөнгө оруулалтын сангийн хувьд хөрөнгө оруулагч нь үнэт цаасны багцад хөрөнгө оруулах зорилго бүхий компанийн хувьцааг худалдан авах замаар тухайн компанийн хувьцаа эзэмшигч болдог. Сангийн хөрөнгийн багцын удирдлагыг сангийн төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгогдсон Хөрөнгө оруулалтын зөвлөх гэрээний үндсэн дээр гүйцэтгэх бөгөөд сангийн хөрөнгө оруулагч буюу хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг тэргүүнд тавьж ажиллах ёстой. Хөрөнгө оруулалтын сангийн ТУЗ нь сангийн өдөр тутмын үйл ажиллагаа болон санд үйлчилгээ үзүүлэгч этгээдүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж сангийн засаглалд чухал үүрэг гүйцэтгэнэ.**
- **Гэрээний бүтэцтэй хөрөнгө оруулалтын сан гэдэг нь сангийн хөрөнгө оруулагч хууль, эрх зүйн хүрээнд оршин тогтнодоггүй үнэт цаасны багцад хувь эзэмших замаар нэгж эрх худалдан авч буй сангийн бүтэц юм.**

Үүсгэн байгуулагдсан улсын хууль, эрх зүйн орчноос хамааран хөрөнгө оруулалтын сан нь сангийн бүтэц харилцан адилгүй байх боловч, дараах хүснэгтэд харуулсан бүтцийн дагуу хөрөнгө оруулалтын сан үйл ажиллагаа явуулдаг.



2021 -06- 25

Бүртгэвнээс оруулалтын сан (БОС)ийн сургалт  
**БҮРТГЭВ-03**



## 2.4 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЗАРДАЛ

Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь өөрийн бизнесийн зорилго стратегиас хамааран хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэн, хөрөнгийн багцыг удирдах хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулах шийдвэрийг бие даан гаргах бөгөөд кастодиан, аудитор, брокер болон үнэт цаасны төлбөр тооцооны үйлчилгээг мэргэшсэн гуравдагч этгээдээр гэрээний үндсэн дээр хийлгэж, үйлчилгээ авдаг. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай болон бусдаас үйлчилгээ авсантай холбоотой гарах зардлыг дараах үндсэн гурван хэсэгт хувааж үздэг ба зардлыг хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөс гаргадаг. Үүнд:

Хүснэгт 4. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой зардал

№	ЗАРДАЛ	ТАЙЛБАР
1	Хөрөнгө оруулалтын менежментийн компанийд төлөх үйлчилгээний төлбөр болон гүйцэтгэлийн урамшуулалт	Энэхүү үйлчилгээний төлбөр нь хөрөнгө оруулалтын менежментийн компанийд төлгөх ба менежментийн компанийн түршлага, сангийн бүтэц, хөрөнгө оруулалтын хэлбэрээс хамааран харилцан адилгүй байна. Олон улсын дунджаас үзэхэд үйлчилгээний төлбөрт жилд 2-3 хувь, гүйцэтгэлийн урамшуулалтад хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хооронд гэрээгээр тохирсон өгөөжкөөс давсан хэмжээнээс жилд 10-20 хувийг төлдөг.
2	Хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлж буй талуудад төлөх төлбөр, шимтгэл буюу хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны зардал	Хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлэгч кастодиан, аудит, брокер, үнэт цаасны төлбөр тооцоо болон хууль зүйн үйлчилгээ зэрэг зардлууд багтдаг. Сангийн бүтэц, хөрөнгийн хэмжээнээс хамааран зэрдлын хэмжээ харилцан адилгүй байдаг
3	Хөрөнгө оруулалтын санг анхлан үүсгэн байгуулахад гарах зардал	Хөрөнгө оруулалтын санг анхлан үүсгэн байгуулахад шаардагдах хөрөнгө татах төвлөрүүлэх, санг бүртгүүлэх зэрэгтэй холбоотойгоор томоохон зардлууд гардаг бөгөөд хөрөнгө оруулалтын банк, зуучал, биржийн бүртгэл, брокер, үнэт цаасны төлбөр тооцоо болон хуулийн зэвлэх үйлчилгээнд энэхүү зардал чиглэгддэг.

## 2.5 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Анхны хөрөнгө оруулалтын сан нь Нидерланд Улсад 1773 онд үүсгэн байгуулагдаж байсан түүхтэй бол 2020 оны байдлаар дэлхий даяар нийт 123 мянга гаруй хөрөнгө оруулалтын сан үйл ажиллагаа явуулж байна.

Хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг бус нутгаар болон төрлөөр нь ангилан харуулсан тоон мэдээллийг дараах графикт харуулав.

Зураг 3. Хөрөнгө оруулалтын сангийн зах зээл, бус нутгаар, 2020



Зураг 4. Хөрөнгө оруулалтын сангийн төрлөөр, 2020




Энэхүү инфографикийн хамгийн түүхийн хувь

Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа АНУ-д хамгийн өргөн дэлгэрсэн буюу нийт хөрөнгө оруулалтын багцын дунгийн 52 хувь нь тус улсад үйл ажиллагаа явуулж байна. Харин Евро бүсийн хөрөнгө оруулалтын зах зээлд Люксенбург, Ирланд, Франц, Герман улсуудад хамгийн олон хөрөнгө оруулалтын сан бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хөрөнгө оруулалтын сангийн багцыг хөрөнгө оруулалт хийгдэж буй хэрэгслээр авч үзвэл хувьцаа 40 хувь, бонд 23 хувь, мөнгөний зах 16 хувь, холимог хэрэгслүүдэд 12 хувь, үл хөдлөх 2 хувь болон бусад хэсэгт 7 хувь байна.

Зураг 5. Дэлхийн хөрөнгө оруулалтын багцудын үзүүлэлт  
бий нийт хувьгоо, ижилдээ доллар



Энэхүү инфографикийн хамгийн түүхийн хувь

**МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГУУДЫН НИЙТ  
ХӨРӨНГӨ УДИРДЛАГА СҮУЛИЙН ЖИЛҮҮДЭД**  
**ТОГТМОЛ ӨСӨЖ 2020 ОНЫ БАЙДЛААР 100 ИХ НАЯД  
АМ.ДОЛЛАРТ ХҮРЧЭЭ.**


СЭХ

2021.06.23 өдөр

БҮРТГЭВ

№ 01

Зураг 6. Хөрөнгө оруулалтын сангийн  
удирдаж буй нийт хөрөнгө, бус нутгийн



Зя сурдэлж. Бостон консалтинг групп  
(Boston consulting group)

**2019 ОНЫ БАЙДЛААР ХОЙД АМЕРИКИЙН БУС НУТАГ ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН САНГИЙН УДИРДАЖ БУЙ ДҮНГЭЭР ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЖ  
БАЙГАА БӨГӨӨД НИЙТ ХӨРӨНГИЙН ТАЛ ХУВЬ НЬ ТУС БУС НУТАГТ НОГДОЖ  
БАЙНА. ҮҮНИЙ ДАРААГААР ЕВРОП ТИВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
САНГУУД 22.8 ИХ НАЯД АМ.ДОЛЛАРЫН ХӨРӨНГӨТЭЙ, АЗИ ТИВ 11.2 ИХ НАЯД  
АМ.ДОЛЛАР БАЙГАА БОЛ ЯПОН БОЛОН АВСТРАЛИИ УЛСУУДЫН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН САНГИЙН ДҮН 6.6 ИХ НАЯД АМ.ДОЛЛАРТ ХҮРСЭН БАЙНА.**

## 2.6 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ

Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаатусгай зөвшөөрөл бүхий үнэтцаасны захзээлийн зохицуулалттай хуулийн этгээд юм.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын зорилго стратегийг тодорхойлох;
- Хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах;
- Хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөгөөг гаргах;
- Санхүүгийн хэрэгслүүдийн үр өгөөж, эрсдэл, хандлагын талаар судалгаа хийж, сонголт хийх;
- Шийдвэр гаргах, багцыг удирдах.

Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааны загварчлал дараах хоёр төрөлтэй байж болдог. Үүнд:

*Хүснэгт 5. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааны загвар*

Хувилбар I	Хувилбар II
<b>Үндсэн үйл ажиллагаа</b>	Хөрөнгө удирдлага + сангийн өдер тутмын зохион байгуулалтын ажлууд, шилжүүлэг, хуулийн үйл ажиллагааг хари уцах
<b>Бусад үйл ажиллагаа</b>	Аудит, кастодианы үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хариуцуулах

Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь олон улсын жишигийн дагуу зөвхөн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үндсэн үйл ажиллагааг эрхлэх, кастодиан, хууль, эрх зүйн ажил зэрэг сангийн бусад үйл ажиллагаанд гуравдагч байгууллагуудыг оролцуулдаг. Эсвэл дан ганц хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахаас гадна хөрөнгө оруулалтын сангийн бусад үйл ажиллагааг давхар гүйцэтгэх боломжтой ба кастодиан, санхүүгийн аудиторын үйлчилгээг зайлшгүй гуравдагч байгууллагаар хийлгэдэг гэсэн үйл ажиллагааны загвартай байж болдог.

Олон улсын хэмжээнд тэргүүлэгч Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн жагсаалтын эхний тавд дараах байгууллагууд ордог.

*Хүснэгт 6. Активын хөрөнгөөр тэргүүлэгч топ 5 компани*

Компанийн нэр	Улс	Нийт хөрөнгө/их наяд ам.доллар (2021Q1)
<b>Blackrock</b>	АНУ/Их Британи	9.0
<b>Vanguard Asset Management</b>	АНУ/Их Британи	7.3
<b>Charles Schwab</b>	АНУ	7.0
<b>Fidelity Investments</b>	АНУ	4.9
<b>Strate Street Global Advisors</b>	АНУ/Их Британи	3.5

Эдгээр активын хөрөнгөөр тэргүүлэгч компаниудын хувьд бизнесийн загварчлал нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахаас гадна сангийн бусад үйл ажиллагааг давхар гүйцэтгэдэг.



2.7 ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭРХ ЗҮЙН  
ОРЧИН

2021 -06- 25



Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль Монгол Улсад 2013 онд анх батлагдсан бөгөөд үүнээс хойш Монгол Улсад одоогийн байдлаар 1 хамтын хөрөнгө оруулалтын сан мөн ойролцоогоор 18 хувийн хөрөнгө оруулалтын сангууд үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус хуулийн дагуу хөрөнгө оруулалтын сан нь хэлбэрийн хувьд хамтын эсхүл хувийн, төрлийн хувьд нээлттэй болон хаалттай байж болох бөгөөд үйл ажиллагаа явуулаххугацаа нь 10 жил хүртэл байх юм. Хөрөнгө оруулалтын сангүүсгэн байгуулах этгээд нь хамгийн багадаа 100 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүхий хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд болох хөрөнгө оруулалтын менежментийн компани байна. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын сангүүсгэн байгуулж "Санхүүгийн Зохицуулах Хороо"-нд бүртгүүлж, гэрээнд заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг санд үзүүлнэ.

Хувийн хөрөнгө оруулалтын санд мөнгөн хөрөнгөөс гадна тухайн хөрөнгө оруулалтын сангийн дүрмээр зөвшөөрсөн тохиолдолд бусад санхүүгийн хэрэгслээр хөрөнгө оруулж болдог бол хувийн хөрөнгө оруулалтын сан нь үйл ажиллагааныхаа хүрээнд дор дурдсан нийт 12 санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах боломжтой. Үүнд:

1. Засгийн газрын өрийн хэрэгсэл;
2. аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
3. нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
4. хаалттай хувьцаат компанийн болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа;
5. зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;
6. зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаггүй компанийн өрийн хэрэгсэл;
7. гадаад улсын Засгийн газраас гаргасан үнэт цаас;
8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;
9. үүсмэл санхүүгийн хэрэгсэл;
10. гадаадын болон үндэсний валют;
11. алт болон бусад арилжаалах боломжтой уул уурхайн бүтээгдэхүүн;
12. үл хөдлөх эд хөрөнгө болон үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших эрх.

Харин хамтын хөрөнгө оруулалтын санд зөвхөн мөнгөн хэлбэрээр хөрөнгө оруулж болдог бол хамтын хөрөнгө оруулалтын сан нь үйл ажиллагааныхаа хүрээнд дор дурдсан зохицуулалттай зах зээлд нийтэд нээлттэй арилжаалагддаг нийт 5 санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах боломжтой. Үүнд:

1. Засгийн газрын өрийн хэрэгсэл;
2. аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
3. нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
4. зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;
5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас.



Хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан дараах дүрэм журмуудыг үйл ажиллагаанд даагаж мөрдөнө. Үүнд:

СЭХ  
Он 2021 сар 06, 22-дээр  
БҮРТГЭВ #01

- Унэт цаасны зах зээлийн тухай хууль /2013/
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль /2013/
- Компанийн тухай хууль /2011/
- Аудитын тухай хууль /2015/
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2015/
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль /2013/
- Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам /2014/
- Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам /2014/
- Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам /2015/
- Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам /2014/
- Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам /2015/
- Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар /2015/
- Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогчийг бүртгэх тухай журам /2016/
- Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох журам /2016/
- Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн мэргэжлийн үйл ажиллагааны болон ажилтны ёс зүйн дүрэм /2016/

Хөрөнгө оруулалтын сан нь дээрх хууль тогтоомж, "Санхүүгийн Зохицуулах Хороо"-ноос тогтоосон шалгуурыг бүрэн хангасны үндсэн дээр тусгай зөвшөөрөл олж авдаг бөгөөд үүнээс гадна "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн шалгуур босго үзүүлэлтүүдийг мөн хангасны үндсэн дээр хөрөнгийн биржээр өөрийн нэгж эрхээ нийтэд санал болгож гаргадаг. Мөн хөрөнгө оруулалтын менежментийн компани нь мөн "Санхүүгийн Зохицуулах Хороо"-нд бүртгэлтэй тусгай зөвшөөрөл эзэмшидэг компани бөгөөд "Санхүүгийн Зохицуулах Хороо"-ноос түүний үйл ажиллагаанд хяналт тавьдаг.

Үүнээс харвал хөрөнгө оруулалтын сан нь дээрх хууль тогтоомж, "Санхүүгийн Зохицуулах Хороо" болон "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн нарийн зохицуулалт, шаардлагуудыг хангасан тусгай зөвшөөрөл бүхий нарийн зохицуулалттай хуулийн этгээд юм.

## 2.8 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

### 2.8.1 Гадаад зах зээл

Дэлхий нийтээр вакцинжуулалт хийгдэж, Хятад Улсын эдийн засаг хурдацтай сэргэж, улмаар түүхий эдийн үнийн супер цикл үүсэж байна гэж олон улсын шинжээчид үзэж байна. Ялангуяа түүхий эдээс хүчтэй хамааралтай манай улсын хувьд энэ нь өсөдтийн мөчлөгтэй зэрэгцүүлэн эдийн засгаа өсгөх том боломж юм.



**Алтны үнэ.** 2020 онд тодорхой бус байдлаас шалтгаалан хөрөнгө оруулагчид алт руу ихээр хөрөнгө оруулж байсан бол 2021 онд вакцинжуулалт эхэлсэнтэй холбоотойгоор 1,752 ам.долларт хүрч буураад байна. Тэсэн хэдий ч 2021 онд 1700 орчимд хадгалагдана гэж үзжээ. Учир нь вакцинжуулалт хийгдсэн ч тодорхой бус байдал их байгаа, түүнчлэн дэлхийн улс орнуудын төв банкууд мөнгөний зөвлөн бодлого барьж байгаа зэрэг нь хөрөнгө оруулагчид алтыг үргэлжлүүлэн барих шалтгаан болж байна.

**Зэсийн үнэ.** Зэсийн үнэ сүүлийн 7 жилийн хамгийн өндөр түвшиндээ хүрч, 9500 ам.доллар болсон хэдий ч эргээд 9,000 ам.доллар болж буураад байна. Зэс бол түүхий эд дундаа дэлхийн эдийн засгийн хандлагыг тодорхойлдог түүхий эд гэдгээрээ онцлог. Нэг талдаа Хятад Улсын эдийн засаг хурдтай сэргэсэн нь зэсийн эрэлтийг нэмэгдүүлсэн бол нөгөө талдаа Чили Улсад цар тахлын нөхцөл байдал намжихгүй байгаа нь нийлүүлэлтийг бууруулж байв. Өөрөөр хэлбэл, эрэлт нийлүүлэлтийн огцом зөрүүнээс болж зэсийн үнэ өсөж байсан. Үүнээс гадна, улс орнууд вакцины үйлдвэрлэлийг эхлүүлж, улмаар эдийн засаг сэргэнэ гэх зэрэг хүлээлт зэсийн үнийг улам өсгөв. 2021 оны эцэст Оросын Холбооны Улсын шинжээчид 8,500 ам.доллар орчимд зэсийн үнийг тогтоно гэж таамаглаж байна. Энэхүү таамагласан үнэ нь манай улсын төсөвт тусгасан зэсийн үнээс 30 орчим хувиар өндөр үнэ юм.

**Нүүрсний үнэ.** Цар тахлын нөлөө Австралийн нүүрсний үнэд хүчтэй нөлөөлсөн ч Монгол Улсын нүүрсний үнэд төдийлөн огцом өөрчлөлтийг бий болгоогүй. Манай нүүрсний экспорт нь тоо хэмжээнээс шалтгаалан огцом буурсан ч нүүрсний үнийн хувьд Хятад улс Австралийн нүүрсний импортод хориг тавьсантай холбоотойгоор Монгол, Оросын Холбооны Улсаас авах нүүрсний импортоо нэмэгдүүлэх төлөвтэй байгаа учир 2021 оны эцэст харьцангуй тогтвортой хэвээр байхаар байна.

Хүснэгт 7. Түүхий эдийн үнийн таамаглал, ам.доллар

	2018	2019	2020	2021*	2022*	2023*	2024*	2025*
Алтны үнэ	1269	1392	1770	1700	1600	1550	1525	1500
Зэсийн үнэ	6530	6010	6174	8500	7500	7555	7611	7667
Нүүрсний үнэ	107	78	61	79	76	74	72	72

Эх сурвалжс Дэлхийн банкны таамаглал

**Төлбөрийн тэнцэл.** Валютын орох, гарах урсгалыг харуулдаг тус үзүүлэлт 2020 онд эдийн засгийн идэвхжил буурсантай холбоотой 700 гаруй сая ам.долларын ашигтай гарсан. Харин 2020 онд валютын томоохон гарах урсгал байхгүй учраас 300-400 орчим сая ам.долларын ашигтай гарахаар байна. Төлбөрийн тэнцэлд экспортын хурдацтай өсөлт, ГШХО-ын өсөлт, гаднаас авах үйлчилгээ багассан зэрэг нь эерэгээр нөлөөлөх төлөвтэй байна.

#### 2.8.2 Дотоод зах зээл

Монгол Улс нь 2016 оны төсвийн болон төлбөрийн хос хямралаас Олон Улсын Валютын Сан ("ОУВС")-ийн хөтөлбөрт хамрагдан, өр төлбөрөө хойшлуулж, эдийн засгаа сэргээж эхлэв. Улмаар 2017 оноос эдийн засаг хурдацтай сэргэж, 2018 болон 2019 онд эдийн засгийн өсөлт 5-7 орчим хувьд тогтвожив. Хэдий тийм ч 2020 оны эхэнд дэлхий нийтийг хамарсан цар тахал гарав. Улмаар 1929 он болон 2008 оны их хямралаас ч илүүтэй гүн цочрол эдийн засагт орж ирсэн.



2021 -06- 25

СЭХ

2021 .06. 23 өдөр

БҮРТГЭВ

Монгол Улс цар тахлаас сэргийлж, дотоодын хөл хорио тогтоож, экспорт ~~жилийн~~ 40 хувь унасан нь 2020 оны 1-р улиралд эдийн засаг 10.7 хувь, 2020 оны эцэст эдийн засаг 5.3 хувиар тус тус агшсан. Өнгөрсөн жил гаруйн хугацаанд 5 удаагийн хөл хорионы дараа эдийн засаг 2021 оны 1-р улиралд 15.7 хувиар өсөж, сэргэсэн. Үүнд уул уурхайн салбарын 34 хувийн өсөлт огцом нөлөөлөв.

**Уул уурхай:** 2021 онд гадаад эрэлт сэргэж, түүхий эдийн үнэ өндөр байгаа зэрэгтэй холбоотой уул уурхайн салбар 10-12 хувиар өсөхөөр байна. Зэсийн баяжмалын хувьд, зэсийн үнэ сүүлийн 7 жилийн хамгийн өндөр түвшиндээ хүрсэн буюу 9,500 ам.доллар болсон мөн Оюутолгойн зэсийн баяжмал дахь алтны агууламжийн хэмжээ 2.5 дахин нэмэгдсэн зэрэг нь зэсийн экспортод эерэгээр нөлөөлөхөөр байна. Харин нүүрсний үнэ харьцангуй тогтвортой төдийгүй (Монгол-Хятад Улс хоорондын үнэ 78 ам.доллар) тээврийн жолоочид вакцинуулалтад хамрагдсанаар экспорт саадгүй гарах нөхцөл бүрдэж байна. Энэ жилийн хувьд, Австралид тавьсан Хятадын хоригтой холбоотой 40 орчим сая тонн нүүрс экспортоор гаргах боломжтой байна.

*Хүснэгт 8. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл, салбаруудаар, хувиар*

	2018	2019	2020	2021-I
<b>ДНБ</b>	7%	5%	-5.3%	15.7%
<b>Хөдөө Аж Ахуй</b>	4%	8%	6.2%	-6.6%
<b>Уул уурхай</b>	6%	0%	-9.4%	34.1%
<b>Боловсруулах</b>	16%	11%	1.3%	21.0%
<b>Цахилгаан</b>	8%	5%	2.0%	7.6%
<b>Барилга</b>	5%	8%	-7.4%	-6.4%
<b>Худалдаа</b>	2%	8%	-11.1%	6.3%
<b>Тээвэр</b>	8%	2%	-20.1%	5.6%
<b>Мэдээлэл</b>	8%	7%	0.4%	3.7%
<b>Үйлчилгээ</b>	5%	6%	-0.8%	2.2%

*Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл, салбаруудаар, хувиар*

**Худалдаа:** Худалдааны салбарын талаас илүү хувийг шатахуун болон уул уурхайн хүнд даацын тоног төхөөрөмжийн худалдаа эзэлдэг. Тэр үүднээсээ худалдааны салбар нь уул уурхайн салбараас хүчтэй хамаардаг. 2021 онд уул уурхайн салбар огцом сэргэхтэй холбоотой худалдааны салбар 5 орчим хувиар өсөхөөр байна. Тодруулбал: Шатахуун, тэр дундаа дизель түлшний худалдаа, хөрөнгө оруулалтын хүнд даацын тоног төхөөрөмжийн худалдаа нь уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн худалдан авалтаар өсөхөөр байна. Харин хурдан эдэлгээтэй бараа, бүтээгдэхүүний худалдаа нь өрхийн худалдан авалтаар түлхүү өсөхөөр хүлээгдэж байна.

**Тээвэр:** Манай улс нь 3 замаар тээвэр хийдэг бөгөөд тээврийн салбарын голлох хэсэг нь авто замын тээвэр, тэр дундаа нүүрсний тээврийн компаниудаар бий болдог. 2020 онд уул уурхай зогссонтой холбоотой тээврийн салбар огцом унасан бол 2021 онд 3 гаруй хувиар өсөхөөр байна. Өсөлтийн голлох нөлөө нь нүүрсний экспорт тасралтгүй үргэлжлэхтэй холбоотой тээврийн компаниудад эерэг нөлөөлнө. Харин дотоодын тээвэр нь хэсэгчилсэн хөл хорио, вакцинуулалт хэрхэн явагдахаас түлхүү хамаарна. Улмаар 2021 оны эхний хагас хүртэл хэсэгчлэн хөл хорих нөхцөл байдал үргэлжлэх магадлал өндөр байна. Агаарын тээврийн хувьд 2021 оны 7-р сараас эхлэх төлөвтэй байгаа нь оны төгсгөлд тус салбар сэргэх боломжтойг харуулж байна.



2021 -06- 25

СЭХ

ОН 2021 САР 25 ЕР

ГҮҮГЭЭВ

№01

**Боловсруулах:** 2020 онд боловсруулах салбар 1.3 хувиар өссөн бол 2021 онд 4 хувиар өсөхөөр байна. Тус салбарын 50 орчим хувийг хүнсний салбар дангаараа бүрдүүлдэг. Тиймдээ ч 2020 онд хүнсний салбар өссөнтэй холбоотой тус салбар өсөлттэй гарав. Харин 2021 оны хувьд, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй жижиг дунд үйлдвэрлэлийн 3 хувийн хүүтэй зээл тус салбарт (жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 30 хувь нь тус салбарт үйл ажиллагаа эрхэлдэг) нэлээд дэмжлэг үзүүлэх ч зээлээ аваад, эргээд сэргэхэд дор хаяж 6 сарын хугацаа шаардагдахаар байна. Учир нь цар тахлын тархалт өндөр, вакцинжуулалтын явц удаан, хөл хорио хэсэгчилж хийгдэж байгаа зэрэг нь бүрэн хүчин чадлаар ажиллах боломжийг нь хязгаарлаж байгаа юм. Нөгөө талдаа тус салбарын гол худалдан авагч өрхүүдийн хувьд, хүнсний болон хүнсний бус зарлага огцом буурсан бөгөөд өрхүүд цаашдаа өндөр худалдан авалт хийх хүлээлт бага байна.

**Барилга:** Манай улсын барилгын бүтээн байгуулалтын 80 хувь нь Улаанбаатар, Өмнөговь (Оюутолгой)-д хийгддэг. 2020 онд барилгын салбар 7.4 хувиар агшсан байна. Хэдийгээр шинэ орон сууцны борлуулалт гадаадаас ирсэн иргэдийн худалдан авалтаар өссөн ч хоёрдогч зах зээл дээрх хуучин орон сууцны борлуулалт огцом буурсан. Түүнчлэн хөл хорионы арга хэмжээ нь барилгын салбарын үйл ажиллагааг бүхэлд нь доголдуулав. 2021 оны хувьд барилгын салбар 3 орчим хувиар өсөхөөр байна. Тус өсөлт нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй 3 их наяд хөтөлбөрийн нөлөөгөөр бий болно гэж харж байна. Тухайлбал: 1 их наяд төгрөгийн санхүүжилт нь барилгын түүхий эд, 2 их наяд төгрөг нь орон сууцны борлуулалтад дэмжлэг үзүүлнэ. Гэсэн хэдий ч энэхүү хөтөлбөр нь 3 жилийн хугацаатай учраас санхүүжилт 2021 онд бүхэлдээ орж ирэх боломжгүй. Энэ онд 6 хувийн хүүтэй орон сууцны хөтөлбөрөөс 1 их наяд төгрөг нь зарцуулагдлаа гэхэд 7000 айлын орон сууцанд санхүүжүүлэх боломж байна. Харин нийлүүлэлт талаасаа зах зээлд 68 мянган айлын 507 шинэ орон сууцны төсөл хэрэгжиж байна. Тиймээс барилгын салбар огцом бус аажмаар өсөх хандлагатай байна.

**Үйлчилгээ:** Тус салбар 2020 оны эхний хөл хорионы дараагаасаажмаар сэргэж байсан ч 2020 оны 11-р сараас дотооддоо цар тахал алдсанаар уналт нь улам даамжирсан. 2020 онд үйлчилгээний салбар 0.8 хувиар агшсан байна. 2021 онд тус салбарын өсөлт нь хөл хорио, вакцинжуулалтаас шууд хамаарахаар байна. 2021 оны эхний хагас хүртэл вакцинжуулалт хүн амын тодорхой хувьд хийгдэж, хөл хорионы арга хэмжээ сулрах нөхцөл бүрдэх үед оны 2-р хагасаас тус салбар сэргэх хүлээлттэй байна. Гэсэн хэдий ч тус салбар энэ онд бүрэн хүчин чадлаараа ажиллах боломж бага байна. Оны эцэст үйлчилгээний салбар 5 орчим хувиар өсөхөөр хүлээгдэж байна. Салбаруудыг задалж авч үзвэл, үзвэр үйлчилгээ, урлаг соёл, боловсрол, зочид буудал, аялал жуулчлал гэх мэт салбаруудад сэргэлт нэлээд удаан ажиглагдахаар байна. Харин санхүү, даатгал, тээврийн салбарын хувьд, бусад үйлчилгээтэй харьцуулахад хурдан сэргэх боломжтой.

2021.06.25  
БҮРТГЭВ-03

СЭХ  
2021.06.23 өдөр  
№01  
БҮРТГЭВ

Ирэх 5 жилд эдийн засагт хэдэн томоохон хүчин зүйлсээс хамаарч өсөхөөр байна. 2022 онд төмөр зам ашиглалтад орсноор нүүрсний экспорт потенциалаар 65 орчим сая тонн гаргах боломж бүрдэнэ. 2023 онд Оюутолгойн далд уурхайн экспорт эхэлснээр одоогийнхоо түвшнээс 2 дахин өсөх боломжтой. Түүнчлэн уул уурхайн түүхий эдийн үнийн супер цикл 2021 оноос эхэлсэн гэх мэт олон зэрэг хүчин зүйлс нь эдийн засгийн өсөлтөд эзэрэгээр нөлөөлөхөөр байна.

Хүснэгт 9 Эдийн засгийн өсөлтийн таамаглал, салбаруудаар, хувиар

	2020	2021*	2022*	2023*	2024*	2025*
ДНБ	-5.3%	4.5%	6.6%	7.3%	6.7%	4.1%
Хөдөө Аж Ахуй	6.2%	3.2%	4.5%	4.2%	5.0%	6.0%
Уул уурхай	-9.4%	12%	7.5%	7.0%	4.1%	6.1%
Боловсруулах	1.3%	4.0%	2.0%	5.3%	4.0%	4.4%
Үйлчилгээ	-0.8%	5.1%	6.0%	5.8%	5.2%	5.0%


Экспорталж Сүүлийн 10 жилийн

### Хүлээгдэж буй эрсдэл, боломж

Ойрын 1, 2 жилийн хугацаанд эдийн засгийн өсөлтийг өсгөх, бууруулах чиглэлд дараах хэд хэдэн эрсдэлийг дурдаж болохоор байна.

Өсөлтийг дэмжигч: 2021 оны хувьд, түүхий эдийн үнэ өндөр байгаа нь эдийн засгийн өсөлтийг хурдастгахаар байна. Түүнчлэн гааль дээр хийгдэж буй шинэчлэлийн арга хэмжээ нь хилийн нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх давуу талтай. 2022 оны сүүлээр, төмөр зам ашиглалтад орж, нүүрсний экспорт нэмэгдэхэд эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна.

Өсөлтийг бууруулж болзошгүй эрсдэл: Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой томоохон төсөл тойрсон улстөржилт бий болох, түүнчлэн вакцинуулалт удаан байж, цар тахлын тархалт нэмэгдсэн үед эдийн засгийн өсөх боломжийг нь хязгаарлах хүчин зүйл болж байна. Түүнчлэн 2022, 2023 онуудад төлөх өр төлбөрийг 2021 онд дахин санхүүжилт хийхгүй нөхцөлд өрийн дефолт зарлаж, ОУВС-ийн хөтөлбөрт орох эрсдэл бий.



2021-06-25

БҮРТГЭВ.03



Цар тахалтай холбоотой эдийн засгийг дэмжих 10 их наяд хөтөлбөр зарласны 4 их наяд орчим нь Монголбанкнаас шууд гарч байна. Ялангуяа хөтөлбөрийн зээлүүдийг банкаар дамжуулан аж ахуйн нэгжүүдэд олгож байна. 2021 оны 1-р улирлын байдлаар 3 хувийн хүйтэй зээл нь 650 гаруй тэрбум төгрөг, репо санхүүжилт 250 тэрбум орчим төгрөг нийтдээ 900 гаруй тэрбумын хөтөлбөрийн зээлийг аж ахуй нэгжүүдэд олгоод байна. Энэ нь банкны зээлийн үлдэгдлийг 2021 оны 1-р улиралд 3 хувиар өсөхөд нөлөөлсөн.

Хэдийгээр 2020 онд бодлогын хүүг 5 нэгж хувиар буулган 6 хувьд хүргэсэн ч банкнуудын зээл олголт төдийлөн нэмэгдээгүй. Тиймээс 2021 онд хүүний түвшин энэ түвшиндээ хадгалагдах боловч 2022 оноос эхлэн өсөх хүлээлттэй байна. Энэ нь мэдээж инфляци, ханшаас шууд хамаарна гэсэн үг.

### Инфляци

Ойрын хугацааны эдийн засгийн сэргэлтийн төлөв нь нийлүүлэлтийн талаас илүү хүчтэй хамаарч байгаа тул инфляцид төдийлөн дарамт болохооргүй хандлагатай байна. Гадаад худалдааны сэргэлт, валютын ханшийн тогтвортажилт зэрэг нь цашид инфляци нам дор түвшинд хадгалагдах үндсэн суурь болж байна. Мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөр нь иргэдийн худалдан авалтыг дэмжихэд шууд чиглээгүй, боловсруулах үйлдвэрлэл, ажлын байрыг дэмжих чиглэлд хуваарилагдаж байгаа тул шууд эрэлтийг өсгөхөөргүй байна. Өөреөр хэлбэл, инфляцийн түвшин нам дор түвшинд буюу Монголбанкны зорилтолт 6+/-2 хувийн хязгаарлалтын хүрээнд байхаар байна.

### Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2020 оны 8-р сараас хойш 2,850 орчимд тогтвортожоод байгаа билээ. Гадаад худалдааны эргэлт буурахын зэрэгцээ, гадаад валютын хүүг бууруулах, төлбөр тооцоог хязгаарласан зэрэг арга хэмжээний үр дүнд гадаад валютын эрэлт хэрэгцээ эрс буураад байна. Ингэснээр гадаад валютын зохиомол эрэлт намжиж, төгрөгийн үнэ цэнэ нэмэгдэх төлөвтэй байна. Цашид Монголбанкнаас уг арга хэмжээг хэвээр үргэлжлүүлэх төлөвтэй бөгөөд гадаад секторын таатай орчин бүрдсэнээр валютын ханш огцом өөрчлөгдөхгүй, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2021 оны эцэс гэхэд 2,890 орчимд хүрэх төсөөлөлтэй байна. Ирэх 5 жилийн хугацаанд томоохон эвентүүд хэрэгжиж эхлэхэд ам.долларын ханш тогтвортой байхаар байна.

Хүснэгт 10. Инфляц болон ханшийн таамаглал, хувийн

	2019	2020	2021*	2022*	2023*	2024*	2025*
<b>Бодлогын хүү</b>	11	6	6	7	7	6	6
<b>Инфляц</b>	5.2	2.3	7.0	6.5	5	4.5	4.2
<b>Валютын ханш</b>	2,727	2,850	2,890	2,940	2,960	2,980	3,000

Эх сурвалж Судлаачийн тооцаатар

Гадаад валютын албан нөөцийн хувьд 2021 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар 4.4 тэрбум ам.доллар байсан бол энэ оны эцэст алт тушаалтын хандлага, төлбөрийн тэнцлийн ашгийн үр дүнд 4.8 тэрбум ам.долларт хурч өсөх боломжтой байна. Саяхан гаргасан Moody's (Moody's) агентлагийн үнэлгээгээр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "Сөрөг" төлөвөөс "Тогтвортой" төлөвт шилжүүлсэн гадаад сектор, төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлэх мэдээлэл байлаа. Түүнчлэн гадаад валютын нийт албан нөөцийг 4.6 тэрбум ам.долларт хүрэх төсөөлөл мөн дэвшүүлсэн байна.



Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээх төлөвлөгөө боловсруулж, улмаар ажлын байрыг дэмжих, жижиг дунд бизнесүүдийг сэргээх чиглэлээр санхүүжилтийн схемүүдийг боловсруулан хэрэгжүүлж байгаа нь санхүүгийн зах зээл бодит сектороо даган сэргэх төлөвтэй байна. Энэхүү хөтөлбөрүүдийн үр дүнд мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, эрч нэмэгдэж 2021 оны эцэс гэхэд М2 мөнгөний нийлүүлэлт 27.4 их наяд төгрөг, жилийн өсөлт 13.2 хувьд хүрэхээр байна.

Нөгөөтээгүүр Монгол Улсын Засгийн газрын зүгээс эдийн засгийг дэмжих бодлого нь Засгийн газрын харилцах, хадгаламжийг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

### Хүүний түвшин

Эдийн засгийн сэргэлт, Монголбанкнаас хэрэгжүүлж буй зөвлөн мөнгөний бодлогын үр дүнд хүүний ерөнхий түвшин үргэлжлэн буурах хандлагатай байна. Тухайлбал 2021 оны эцэс гэхэд төгрөгийн зээлийн хүү 13.6 хувьд хүрч буурах буюу одоогийн түвшнээс 1.5 нэгж хувиар доогуур, гадаад валютын зээлийн хүү 8.7 хувьд хүрч буурах буюу одоогийн түвшнээс 0.5 нэгж хувиар доогуур болох зэрэг төсөөлөл байна. Энэхүү хүүний ерөнхий түвшин буурахад харилцах болон хугацаагүй хадгаламжийн хүү тооцохыг хориглосон шийдвэр, бодлогын хүүний бууралт, арилжааны банкнуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ хангалттай хэмжээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар хангалттай хэмжээнд хурсэн нь эерэг нөлөөллүүд үзүүлсээр байна.

### Зээл олголт

Цар тахлын нөлөөгөөр арилжааны банкнуудын зээлийн эргэн төлөлт удааширч, зээлийн чанар, хугацаа хэтэрсэн зээл нэмэгдсэн хэдий ч Монголбанкнаас тогтоосон журам, тушаалын дагуу зээлүүдийн бүтцэд өөрчлөлт орж, хүү буурах, хугацаа хойшлуулах арга хэмжээнүүд шат дараатай хэрэгжээд байна.

Цаашид дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өндөр байх, экспортын гаргалт нэмэгдэх, гадаад валютын орлого нэмэгдэх, улсын төсвийн орлого нэмэгдэх, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа сэргэх, үндсэн салбаруудад өсөлт бий болох зэрэг Монголын эдийн засаг сэргэхээр хүлээгдэж байгаа нь арилжааны банкнууд дахь зээлийн эргэн төлөлт, эргэлт сайжрах эерэг нөлөөлөл үзүүлэхээр байна. Эдгээрийн үр дүнд банкнуудын ашигт ажиллагаа өсөх, улмаар өөрийн хөрөнгө нэмэгдэх эргээд эдийн засгаа санхүүжүүлэх эдийн засгийн сэргэлтийн мөчлөг рүү орохоор байна.

Тухайлбал арилжааны банкнуудын иргэд, аж ахуй нэгжүүдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 2-р сарын эцсийн байдлаар 17.1 их наяд төгрөг байсан бол 2021 оны эцсийн байдлаар 19.1 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 11.2 хувьд хүрэхээр байна.

### 2.8.3 Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал

Хөрөнгийн зах зээл сүүлийн 5 жил эрчимтэй хөгжиж байна. 2020 оны байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 3 их наяд төгрөгт хүрч, санхүүгийн салбарын 7 хувийг хөрөнгийн зах зээл бүрдүүлж байна. Хүмүүсийн санхүүгийн мэдлэг нэмэгдэхийн хэрээр орлогын олон эх үүсвэр хайж, хөрөнгө оруулах сонирхол ч нэмэгдэж байна. Ирэх 5 жилийн хугацаанд төмөр зам, Оюу толгойн далд уурхай гэх мэт томоохон төслүүдийн нөлөөгөөр эдийн засаг сэргэж, улмаар өрхүүдийн орлого ч даган нэмэгдэхээр байна. Энэ нь хөрөнгийн зах зээлийн идэвхжлийг нэмэгдүүлнэ гэж харж байна. Түүнчлэн 2022 оны хагас жилээс өмнө системийн нөлөө бүхий банкууд нь олон нийтэд нээлттэй компани болохор хуульчидсан УЛААНБАATAR ХОТ нь Монголын хөрөнгийн зах зээлд маш том өсөлтийг бий болгох юм.






Эх сурвалж "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК

Эдгээр хөрөнгийн зах зээлийн өсөлт нь хөрөнгө оруулагчдын хувьд маш том боломж хэмээн харагдаж байна. Хэдий ирээдүйг 100 хувь таамаглах боломжгүй ч, өнгөрсөн хугацааны үзүүлэлттээс тодорхой төлөвийг олж харж болдог. Банкны салбарын хувьд сүүлийн 15 жилийн хугацаанд өөрийн хөрөнгө нь 33 дахин өссөн гайхамшигтай үзүүлэлттэй байна. Нэгэнт манай улс нь хөгжиж буй зах зээл тул үүнээс цаашид ч өсөх боломж бүрэн харагдаж буй юм.

Зураг 8. Монголын арилжааны банкнуудын зорилтуудын хувь



Эх сурвалж Монголбанк

"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК дээр одоогоор бүртгэлтэй байгаа топ хувьцаануудын хувьд мөн л адил өндөр өсөлт үзүүлсэн юм. 2020 онд огцом өсөлтийг үзүүлсэн, цар тахалтай жил байсан хэмээн хугацааны цуваанаас хасвал ТОП 20 индекс 2004 оноос 2019 оны хугацаанд 90 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2021-06-25

## 2.8.4 Хөрөнгийн биржийн арилжааны тухай



"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 248 удаагийн арилжаагаар 144 компанийн 353.2 сая ширхэг хувьцааг 53.9 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 5.8 мянган ширхэг үнэт цаасыг 586.8 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 50.4 сая ширхэг нэгж эрхийг 5.07 тэрбум төгрөгөөр, компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 57.9 мянган ширхэг бондыг 5.7 тэрбум төгрөгөөр арилжиж, нийт 65.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.<sup>1</sup>

Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлдог гол индикаторуудын нэг бол зээлийн үнэлгээ болон ТОП-20 индекс юм. "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК нь "Үнэт цаасны үнийн индекс тооцоолох журам"-ын дагуу бүртгэлтэй компаниудыг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал зэрэг үзүүлэлтүүдээр үнэлж, ТОП-20 индексийн багцыг бүрдүүлдэг ба тухайн багцыг жил бүр шинэчилдэг. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 21,888.16 нэгж, доод үзүүлэлт 17,922.82 нэгж, дундаж үзүүлэлт 19,978.13 нэгж байна. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,844.90 нэгжээр буюу 8.59 хувиар буурч, 19,621.86 нэгж болсон байна. Зах зээлийн үнэлгээний хувьд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжаалагдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 3 их наяд 26.5 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 336.2 тэрбум төгрөгөөр буюу 12.50 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.<sup>2</sup>

### З“МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ”ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

#### 3.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сангийн нэр	"Мандал Ирээдүйн Өсөлт" Хамтын хөрөнгө оруулалтын сан
Сангийн регистрийн дугаар	6702988
Сангийн улсын бүртгэлийн дугаар	9011827609
Санг бүртгэсэн огноо	2021.06.11
Сангийн хэлбэр	Хамтын
Сангийн төрөл	Хаалттай
Үйл ажиллагаа явуулах хугацаа	10 жил
Нийтээс татан төвлөрүүлэх зорилтолт нийт дүн	Тавин тэрбум (₮50,000,000,000) төгрөг хүртэлх
Нийтэд санал болгох нэгж эрхийн тоо	Дөчин долоон сая таван зуун мянга (47,500,000) ширхэг

<sup>1</sup>"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн 2020 оны Үнэт цаасны арилжааны тайлан;

<sup>2</sup>"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн 2020 оны Үнэт цаасны арилжааны тайлан;



2021 -06- 25

Нэг мянган (₮1,000) төгрөг

Нэгж эрхийн нэрлэсэн үнэ

**СЭХ**  
**2021 . 06 . 23 өдөр**  
**БҮРТГЭВ**  
**№ 01**

Сангийн удирдлага

**БҮРТГЭВ №3**

Нэгж эрхийн зээмшигчдийн хурал

Санал болгох хүрээ

Олон нийт

Хөрөнгө итгэмжлэн удирдах  
компани

“Мандал Ассет Менежмент УЦК” ХХК

Хөрөнгө хадгалах кастодиан

“Голомт Банк” ХХК– Кастодиан банкны хэлтэс

Шимтгэлийн бүтэц

Удирдаж буй хөрөнгийн хэмжээнээс (AUM): 1%  
Цэвэр активын үнэлгээний (NAV) өсөлтийн: 10%

Хөрөнгө оруулалтын багц

Тэнцвэртэй: Хувьцаа < 70%, Тогтмол орлоготой үнэт цаас < 80%,  
Бусад < 20%

Хөрөнгө итгэмжлэн хадгалах

Голомт банк – Кастодиан банкны хэлтэс

Хөрөнгө хэлбэр

Монголын хөрөнгийн биржийн хоёр дахь зах зээлийн  
арилжаа

Нэгж эрхийн үнэ тогтох хэлбэр

Хөрөнгө оруулалтын сангийн цэвэр активын үнэлгээн дээр  
үндэслэгдэн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр тогтоноАрилжааг зохион байгуулах  
байгууллага

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК

Холбоо барих хаяг

Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Жамъян-Гүний,  
Меру тауэр, 602 тоот  
Утасны дугаар: 7272 9911  
Имэйл хаяг: support@mandalasset.mn

Сан нь Монгол Улсын “Хөрөнгө оруулалтын сангийн тухай” хууль, Компанийн тухай хууль, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль, “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ны холбогдох журмуудын дагуу үүсгэн байгуулагдсан бөгөөд “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ноос олгосон хөрөнгө оруулалтын сангийн хэлбэрээр үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д бүртгэлтэй хуулийн этгээд болно. Сан нь хөрөнгө оруулагчдынхаа хөрөнгийг хөрөнгийн зах зээлийн топ хувьцаануудад идэвхтэй хөрөнгө оруулалт хийх замаар өсгөх зорилготой болно.

### 3.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Сан нь зах зээлийн нэхцэл байдалтай уялдуулан хөрөнгө оруулалтуудыг эрсдэлийн зохих түвшинд, өндөр өгөөж олох зорилгоор хийх болно. Хөрөнгө оруулалтын багц нь томоохон нээлттэй компаниудын хувьцаа болон тогтмол орлоготой үнэт цаасаас бүрдэнэ. Эдийн засгийн нэхцэл байдал болон нэгж эрхээзэмшигчдийн хүсэл сонирхол дээр үндэслэн багцад эзлэх хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдийн хувь нь хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгээр өөрчлөгджэй болно. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан хөрөнгө оруулалтын багцын ангилалд хамаарах хязгаарлалтын хүрээнд багтаан багцын дийлэнх хувийг буюу 50-с дээш хувийг “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК дээрх топ хувьцаат компаниудад хөрөнгө оруулах төлөвлөгөөтэй болно.

Сангийн хөрөнгө оруулалтын стратеги нь “income investing” буюу “тогтмол орлого бий болгох хөрөнгө оруулалтын багц бүрдүүлэх хөрөнгө оруулалтын стратеги” болон “growth investing” буюу “хөрөнгө оруулагчийн хөрөнгийг өсгөх зорилготой хөрөнгө оруулалтын стратеги”-г хослуулах юм. Өөрөөр хэлбэл Сан нь худалдан авсан үнэт цаасын



2021 - 06 - 25

БҮРТЭЗВ-03

СЗХ

ОН сар... вдэр

2021 - 06 - 25

БҮРТЭЗВ № 01

цаашид нэмэгдүүлэх стратегийн алхмуудыг хэрэгжүүлж, өсөлтийг бий болгоно. "Income investing" стратегийн хувьд тогтмол орлоготой үнэт цаасанд сангийн хөрвөх чадварыг хангах зорилгоор хөрөнгө оруулна. Үүнд, эрсдэл багатай, хөрвөх чадвар сайтай, нээлттэй үнэт цааснуудыг сонгон авна. Түүнчлэн олон улсын зээлжих зэрэглэлтэй үнэт цаасыг илүү эрсдэл багатай хэмээн үзэж, хөрөнгө оруулах төлөвлөгөө байна. Харин "growth investing" стратегийн хувьд хамгийн өндөр өгөөжтэй байх үнэт цаасны багцыг бүрдүүлснээр тухайн үнэт цаасны ногдол ашгаас тогтмол өгөөжийг бий болгоо зорьж ажиллана.

2021 оны хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт үндэслэн дараах багцыг бүрдүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

*Хүснэгт 11: Хөрөнгө оруулалтын багцын төлөвлөгөө*

### Хөрөнгө оруулалтын ангилал Багцад эзлэх хувь

Нээлттэй өмчлөлийн хэрэгсэл	70.0%
Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл	25.0%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5.0%

#### 3.2.1 Нээлттэй өмчлөлийн хэрэгсэлд хөрөнгө оруулах стратеги

Нээлттэй өмчлөлийн хэрэгсэл гэдэг нь олон нийтийн хэлж заншсанаар хувьцааны хөрөнгө оруулалт юм. Бид цаашдаа өсөх боломжтой, гэхдээ тогтвортой мөнгөн урсгалтай компаниудад төвлөрөн хөрөнгө оруулахаар төлөвлөөд буй. Тухайн хувьцааны сонголтыг бид дараах хүчин зүйлс дээр үндэслэн хийх болно.

Санхүүгийн үзүүлэлтүүд	Үнэт цаас гаргагчийн ашиг болон хувьцааны дансны үнэ нь зохистой түвшинд байх <sup>3</sup>
Удирдлага, хүний нөөц	Үнэт цаас гаргагчийн ирээдүйн өсөлт нь тэнд ажиллаж буй хүмүүсээс шууд хамаардаг. Иймд хүний нөөц нь тогтвортой, удирдлага туршлага, чадвартай эсэх
Зах зээлийн сегмент	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн өөрчлөлт, шинэчлэл болон ирээдүйд өсөх боломжтой эсэх
Өрсөлдөгчид	Үнэт цаас гаргагчийн зах зээлдээ эзлэх байр суурь, өрсөлдөгчдийн чадавх

Дээрх хүчин зүйлс дээр үндэслэн компанийн бодит үнэлгээг гаргах ба тэрхүү үнэлгээг олон нийтэд арилжаалагдаж буй үнэтэй харьцуулах замаар хувьцааны сонголтыг хийнэ. Түүнчлэн нэгэнт худалдан авсан компанийн хувьцааг цаашид нэмэгдүүлэх стратегийн өөрчлөлтүүдийг хийх болно.



<sup>3</sup> Зохистой түвшин нь эдийн засгийн нөхцөл байдллас хамааран тогтоно

**3.2.2 Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах стратеги**

**БҮРТГЭВ-03**

Өрийн хэрэгслийн хөрөнгө оруулалт нь өндөр өсөлтийг гаргахад чиглэсэн бус хөрвөх чадварыг хангахад зориулагдсан болно. Иймд бид эрсдэл багатай богино болон урт хугацааны өрийн хэрэгсэл худалдан авахаар төлөвлөөд байна. Үүнд бид дараах шалгуураар тухайн өрийн хэрэгслийг сонгох болно:

**Мөнгөн урсгал**

Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгал тогтвортой буюу эргэн төлөлтийг хийх чадвартай байх

**Хөшүүрэг**

Бизнесийн онцлогоос хамааран хөшүүргийн зэрэг нь хэт өндөр биш байх

**Бизнес**

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны эрсдэлийн түвшин бага байх

**3.2.3 Хөрөнгө оруулалтын хэрэгслийн хязгаарлалт**

Сан нь өөрийн хөрөнгөө доорх хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээс өөр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно. Үүнд:

- Засгийн газар, Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
- Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
- Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;
- Санхүүгийн Зохицуулах Хороо болон нэгж эрх эзэмшигчдийн хурлаар зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгсэл.

Сангийн активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоодог бөгөөд Сан нь уг хууль, журмын шаардлагад нийцүүлэн ажиллана.

**3.2.4 Хөрөнгө оруулалтын судалгаа**

Сангийн менежер нь Санг бага эрсдэл өөртөө авч, өндөр өгөөж авах боломжтой байдлаар хөрөнгө оруулалт хийх боломжоор хангах үүрэгтэй. Үүний тулд санхүүгийн зах зээлийн ахисан түвшний судалгаа болон Монголын санхүүгийн зах зээлийн практик туршлагыг хослуулан ашиглана. Судалгааг үндсэн гурван түвшинд гүйцэтгэх ба үүнд:

1. Макро эдийн засгийн судалгаа

Эдийн засгийн ерөнхий цикл нь хувьцааны үнэлгээнд шууд хамаардаг. Иймд богино болон дунд хугацааны эдийн засгийн төсөөлөл гаргах, үүндээ салбар бүрийн өсөлтийг таамаглал гарган ажиллах болно. Тус таамаглалд олон улсын судалгааны байгууллага, дотоодын судалгааны байгууллагуудын гаргасан төсөөлөл болон өөрсдийн "Vector Auto Regressive" загвараар гаргасан төсөөллийг ашиглана.

2. Салбарын судалгаа

Эдийн засгийн ерөнхий циклээс илүүтэйгээр тухайн компанийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн салбар нь чухал нөлөөтэй байдаг. Үүнд Портенийн хүчин зүйлийн шинжилгээ хийх замаар тухайн салбарыг ерөнхийлөн таньж болдог. Ийнхүү салбарын ерөнхий дүр зургийг хамгийн эхэнд гарган аван ажиллана. Үүний дараагаар тухайлсан



зах зээлийн тоон үзүүлэлтүүд дээр эдийн засгийн суурь загварууд ашиглан таамаглал, судалгааг хийж гүйцэтгэх юм.

## БҮРТГЭВ-03


### 3. Компанийн шинжилгээ

Компанийн нөөц бололцоо, санхүүгийн үзүүлэлтүүд, удирдлагын чадвар гэх мэт олон хүчин зүйлийг үнэлэн компанийн бодит үнэлгээг тооцон гаргадаг. Өөрөөр хэлбэл компанийн үнэлгээ нь тоон болон чанарын хүчин зүйлсийн нийлбэр болдог. Иймд сонгон авсан болон сонгохоор зэхэж буй компанийн үнэлгээг P/E, P/B, DCF, EBITDA multiplier зэрэг тоон аргуудыг чанарын хүчин зүйлүүдтэй хослуулан гаргах ба сангийн менежерийн зүгээс хямд, цаашид өсөх боломжтой хэмээн үзсэн компаниудыг сонгон хөрөнгө оруулна.

## 3.3 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 3.3.1 Сангийн үйл ажиллагааны схем

Зураг 3. Сангийн үйл ажиллагаа



### 3.3.2 Нэгж эрх эзэмшигчдийн хурал

Сангийн эрх барих дээд байгууллага нь Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурал бөгөөд уг хурал нь хуулийн дагуу Сангийн онцгой шийдвэрийг гаргахад оролцох, Сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, Сангийн Төлөөлөн Удирадах Зөвлөл ("Сангийн ТУЗ")-ийн гишигдийг сонгох зэрэг эрхтэй. Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Сангийн дүрмээр тодорхойлсон бөгөөд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл нэгэн адил хамаарна. Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурал нь Сангийн дүрмийн 9.2-т заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд:

- хөрөнгө оруулалтын менежментийн компанийг сонгох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах шийдвэр гаргах;
- кастодианыг сонгох, хөрөнгө хадгалах гэрээ байгуулах шийдвэр гаргах;
- Сангийн ТУЗ-ийн гишигдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

2021 -06- 25

БАРТАСУУЛЫН  
ДЭЭД ХЯЗГААРЫГ ТОГТООХ

№03

СЭХ  
он... сар... өдөр  
2021 РУГ. ГЭВ  
№ 01

- хөрөнгө оруулалтын менежментийн компани болон кастодианы төлбөр, урамшууллын дээд хязгаарыг тогтоох;
- Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон Сангийн үйл ажиллагааны тухай журамд заасан бусад асуудлыг шийдвэрлэх.

Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байх ба ээлжит хурал нь жилд нэг удаа хуралдах бол ээлжит бус хурлыг Сангийн дүрэмд зааснаас гадна дараах тохиолдолд хөрөнгө оруулалтын менежментийн компани зарлан хуралдуулна. Үүнд:

- (1) Сангийн үйл ажиллагааны явцад цэвэр активын хэмжээ нь дараалсан арав (10) хоногийн туршид тухайн сарын үйл ажиллагаа эхэлсэн өдрийн хэмжээнээс дөчин (40%) хувь буурсан;
- (2) Хөрөнгө оруулалтын менежментийн компани татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсон эсхүл бусад шалтгааны улмаас шинээр хөрөнгө оруулалтын менежментийн компанийд хөрөнгө итгэмжлэн удирдах эрхийг шилжүүлэх шаардлага үүссэн;
- (3) Кастодиан татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсон эсхүл бусад шалтгааны улмаас шинээр хөрөнгө хадгалах гэрээний эрхийг өөр кастодианд шилжүүлэх шаардлага үүссэн;
- (4) Сан татан буугдах, дампуурах нөхцөл байдал үүссэн;
- (5) Хөрөнгө оруулалтын менежментийн компаниас Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурлыг хийхийг шаардсан бусад шаардлага.

### 3.3.3 Төлөөлөн удирдах зөвлөл

Сангийн ТУЗ нь хамтын удирдлага бүхий бүтэц бөгөөд Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Сангийн эрх барих байгууллага юм. Сангийн ТУЗ нь Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгө оруулалтыг хамгаалах, Санг үр ашигтай шийдвэр гаргах, үйл ажиллагааг хянах, стратегийг тодорхойлж ажиллана.

Сангийн ТУЗ нь холбогдох хууль тогтоомж болон Сангийн дүрэмд тодорхойлсноос гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- (1) Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- (2) Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал болон нэгж эрх эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- (3) Сангийн зарласан нэгж эрхийн тоонд багтаан нэгж эрх гаргах;
- (4) Хөрөнгө оруулалтын менежментийн компанийд олгох үйлчилгээний төлбөр, гүйцэтгэлийн урамшууллыг батлах;
- (5) Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлсэн аудитын байгууллагуудаас Сангийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, гүйцэтгэх удирдлагад түүнтэй гэрээ байгуулах эрхийг олгох;
- (6) Сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж батлуулах;
- (7) ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- (8) Сангийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон Сангийн засалтальны Улаанбаатар хот



2021 -06- 25



- дотоод журмыг батлах;
- (9) Санг нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах талаар нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- (10) их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- (11) сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- (12) Сангийн дотоод хяналтын хорооны гишүүдийг томилох;
- (13) Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой бусад журамд заасан бусад асуудлыг шийдвэрлэх.

Сангийн ТУЗ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийн 2 нь хараат бус гишүүн байна. Сангийн ТУЗ-ийн гишүүд нь сонирхлын зөрчилгүй, хараат бусаар Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэн ажиллах ба ингэхдээ Сангаас аливаа цалин урамшуулал авахгүй. Сангийн ТУЗ-ийн гишүүд нь банк, даатгал, үл хөдлөх хөрөнгө зэрэг салбарт ажиллаж байсан арвин туршлага, чадвартай болно.

Сангийн ТУЗ-ийн гишүүд дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:



**Ө.Ганзориг**  
**Сангийн ТУЗ-ийн дарга**

Ө.Ганзориг нь 2002 онд Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийг няглан бодогч мэргэжлээр, 2007 онд Маастрихтын менежментийн их сургуулийг санхүүгийн удирдлага чиглэлээр тус тус төгссөн. 2007 оноос эхлэн Улаанбаатар хотын банканд дэд захирал, Хас банканд зөвлөх, Тэнгэр даатгалын гүйцэтгэх захирал, 2010 онд Мандал даатгал компанийн ерөнхийлөгч албан тушаалыг хашиж байсан туршлагатай бөгөөд Голомт банкны ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал албан тушаалуудыг тус тус хашиж байсан. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Монголын банк, даатгал, санхүүгийн салбарт өөрийн үнэтэй хувь нэмрээ оруулан ажиллаж байгаа бөгөөд 2005 оноос Санхүүгийн зах зээлийн холбоо ТББ-ыг үүсгэн байгуулж өнөөдрийг хүртэл үйл ажиллагааг нь амжилттай удирдан явуулж байна.

**Н.Монсор**  
**Сангийн ТУЗ-ийн гишүүн**



Н.Монсор нь Шинжлэх ухаан компьютерын сургуулийг төгссөн, программ хангамжийн магистр зэрэгтэй. 2009 оноос хойш үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дагнан ажилласан туршлагатай бөгөөд үл хөдлөх хөрөнгийн санхүүгийн менежментийн чиглэлээр Хонгконг-д мэргэжил дээшлүүлсэн. 2011 оноос хойш үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр дагнан ажиллаж байгаа бөгөөд нийт 150 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг амжилттай удирдаж байна.





### Ч.Даваадаш

#### Сангийн ТУЗ-ийн гишүүн

Ч. Даваадаш нь 2001 оноос эхлэн Монгол улсын харилцаа холбоо, нефть хангамж, банк санхүү зэрэг салбаруудад ажиллаж ирсэн туршлагатайгаас сүүлийн 10 гаруй жил нь ажиллаж буй компанийнхаа удирдлагын түвшинд ажилласан. 2008 оноос Ньюком, Мобиком группийн Ньютел компанийн гүйцэтгэх захирал, Петровис группийн НИК компанийн дэд захирал, гүйцэтгэх захирал, Скайтель компанийн дэд захирал, Голомт банкны газрын захирал, гүйцэтгэх захирлын орлогчоор тус тус ажилласан туршлагатай. Одоо “Мандал Даатгал” ХК-ийн ерөнхийлөгчөөр ажиллаж байгаа бөгөөд эдийн засаг, бизнесийн удирдлагын мастер зэрэгтэй.



### Ц.Батсүх

#### Сангийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ц.Батсүх нь Монголын улсын тэргүүлэх эдийн засагчийн нэг юм. Тэрээр СЭЗИС-ийн тэнхимийн профессор бөгөөд Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн хараат бус гишүүнээр ажилладаг. Ц.Батсүх нь хэрэглээний математикийн шинжлэх ухааны магистр, эдийн засгийн ухааны доктор (Ph.D) профессор цолтой. Өнгөрсөн хугацаанд эдийн засгийн чиглэлээр олон тооны төсөлд зөвлөх хийж байсан ба эдийн засгийн нөхцөл байдлын тухай тогтмол ярилцлага өгдөг билээ.



### Ч. Анхбаяр

#### Сангийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ч. Анхбаяр нь 2006-2011 онд Хадгаламж, Тээвэр хөгжлийн банк болон Анод банканд эрсдэлийн удирдлагын газрын захирал, 2012-2016 онд Мандал Даатгал компанийн ахлах менежер, 2016-2017 онд Азийн Хөгжлийн Банкны төсөлд зөвлөх, 2018 оноос одоог хүртэл МУИС-Бизнесийн сургуульд ахлах багшаар ажиллаж байна. Ч. Анхбаяр нь Монгол Улсын Их сургуулийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийг хэрэглээний математикийн магистр, бизнесийн удирдлагын докторын зэрэгтэй.



2021 -06- 25



### 3.3.3.1 Дотоод хяналтын хороо

Сангийн ТУЗ нь доороо дотоод хяналтын хороотой байна. Дотоод хяналтын хороо нь Сангийн үйл ажиллагаанд болон Сангийн менежерийн үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх, кастодианы үйл ажиллагаанд хяналт тавих зэрэгчигүүргийг хэрэгжүүлэн ажилладаг нэгж юм. Тус дотоод хяналтын хороо нь Сангийн ТУЗ-өөстомилогдож, өөрийн үйл ажиллагааг Сангийн ТУЗ-д тайлгагнаа. Дотоод хяналтын хороо нь аудитын үйл ажиллагаа явуулах эрх авсан, энэ чиглэлээр ажилладаг туршлагатай дараах гурван (3) гишүүнтэй байна. Үүнд:

#### **Г. Гантулга - Дотоод хяналтын хорооны дарга**

Г. Гантулга нь СЭЗИС-ийн ОУНББСМС-ийн захирлаар ажилладаг. Өмнө нь тэрээр ЭМОН ХХК-д багш, тэнхимиийн эрхлэгч, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуульд багшаар ажиллаж байсан туршлагатай. Г. Гантулга нь 2002 онд Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийг нягтлан бодогч мэргэжлээр бакалаврын зэрэгтэйгээр төгсөж, 2004 онд ХУДС Бизнесийн удирдлага, 2015 онд СЭЗИС Бизнесийн удирдлагын магистр зэргээ тус тус хамгаалсан байна.

#### **Б. Энхтувшин - Дотоод хяналтын хорооны гишүүн**

Б. Энхтувшин нь Мандал Даатгал ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажилладаг. Тэрээр өмнө нь банк санхүүгийн салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд гадаад төлбөр тооцооны албаны дарга, нөөцийн газар болон санхүүгийн газрын захирлаар тус тус ажиллаж байсан. Б. Энхтувшин нь Монгол Улсын Их сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, магистрын зэрэгтэйгээр тус тус төгссөн.

#### **Г. Батзориг - Дотоод хяналтын хорооны гишүүн**

Г. Батзориг нь "Мандал Санхүүгийн Нэгдэл" ХХК-ийн ерөнхий эдийн засагч бөгөөд өмнө нь "Грандлайн БДК"-н хөрөнгө оруулалтын шинжээч, Хас Банканд зээлийн багцийн аналист, макро эдийн засгийн шинжээч, Голомт Банканд макро эдийн засагч, ахлах эдийн засагчаар тус тус ажиллаж байв. Тэрээр дэлхийн болон Монголын эдийн засаг, макро эдийн засгийн судалгааны ажилд оролцож байсан. Тэрээр МУИС-н Эдийн засгийн сургуулийг эдийн засагч мэргэжлээр бакалавр, Туркулсад Сакаряя их сургуульд эконометрик, эдийн засгийн чиглэлээр магистр хамгаалсан.

### 3.3.4 Гүйцэтгэх удирдлага

"Мандал Ассет Менежмент УЦК" ХХК ("ХОМК") нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хөрөнгө оруулалтын менежментийн компани бөгөөд Санг үүсгэн байгуулж, Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн зохион байгуулах, хөрөнгө оруулалтын шийдвэр бие даан гаргах, Сангийн хөрөнгийг удирдан зохион байгуулах зэрэг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

ХОМК нь Сантай байгуулсан гэрээний дагуу дараах үйлчилгээг санд үзүүлнэ. Үүнд:

- Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- Хөрөнгө оруулалтын бодлогын дагуу сангийн хөрөнгийг удирдаж, хөрөнгө оруулалт хийх;
- Санг төлөөлөх, бусадтай гэрээ байгуулах, Сангийн хөрөнгийг захиралт зориулж УЛААНБААТАР ХОТ



2021 - 00 - 21

**БҮРТГЭВ-03**

- хэлцэл хийх;
- Сангийн зардлыг Сангийн хөрөнгөөс гаргаж, төлөх;
  - Сангийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай журам, заавар гаргаж, түүнийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах;
  - Шаардлагатай бол Сангийн ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
  - Санг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох;
  - Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, түүнтэй холбоотой мэдээлэл, тайлан бэлтгэх;
  - Сангийн хөрөнгийг тусгаарлаж Сангийн нэр дээр нээсэн тусдаа дансанд байршуулж, эрх бүхий кастодиан банкинд хадгалуулах;
  - Сангийн тайлан мэдээнүүдийг гаргаж тайлагнах;
  - Сантай байгуулсан гэрээнд тусгасан нөхцөлийн дагуу нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах;
  - Сангийнүйлажиллагаагдуусгавар болгосон өдрөөсэхлэн Сангийнүйлажиллагааг зогсоож, татан буулгах үйл ажиллагааг зохион байгуулах, Сангийн хөрөнгийг Сангийн дүрэм болон хууль тогтоомжид заасны дагуу нэгж эрх эзэмшигчдэд хуваарилах;
  - Сангийн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хадгалах, хуульд заасан хугацаанд холбогдох төрийн байгууллагуудад санхүүгийн тайланг гаргаж хүргүүлэх ажлыг кастодианаар хөрөнгө хадгалах гэрээний үндсэн дээр хийлгэх;
  - Сангийн нэгж эрх эзэмшигчдийн бүртгэлийг нэгж эрхийн тухайлсан бүртгэлд үндэслэн хөтөлж, түүнийг хадгалуулах ажлыг зохион байгуулах;
  - Сангийн зар сурталчилгаа болон Сангийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх зэрэг маркетингийн үйл ажиллагааг зохион байгуулах;
  - Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд тусгасан бусад үйлчилгээ.

ХОМК нь Сангийн менежерийг томилох ба дээрх үйлчилгээг хийх гүйцэтгэхдээ ХОМК нь Сангийн менежерээр дамжуулан үзүүлнэ. Сангийн менежер нь Сангийн гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.



**Г.Ганзориг**  
**Сангийн менежер**

Г.Ганзориг нь "Мандал Ассет Менежмент УЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал бөгөөд хөрөнгө оруулалт, санхүү болон үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Тэрээр өмнө нь Мандал Даатгалын хөрөнгө оруулалт хариуцсан захирал, Голомт Банкны ахлах макро эдийн засагч, Юу Эм Си Альфа болон Мандал Даатгал компанийн санхүүгийн шинжээчээр тус тус ажиллаж байсан. Тэрээр Санхүү Эдийн Засгийн Их сургуулийг санхүүгийн удирдлагын бакалавр, Английн Лийдсийн их сургуулийг эдийн засгийн ухааны магистр зэргээр дүүргэсэн.



### 3.3.5 Сангийн бүтэц, зохион байгуулалтад оролцогч бусад талууд

Кастодиан, аудит, үнэлгээ, брокер, үнэт цаасны төлбөр тооцоо зэрэг үйлчилгээг үзүүлдэг этгээдүүд Сантай гэрээ байгуулан, уг гэрээний хурээнд Санд үйлчилгээ үзүүлнэ.

#### 3.3.5.1 Кастодиан

Кастодиан нь Сантай байгуулсан хөрөнгө хадгалах гэрээний үндсэн дээр Сангийн нэгж эрхийн тухайлсан бүртгэл, хадгалалтыг хариуцан ажиллах, ХОМК-ийн үйл ажиллагааг Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт нийцэж байгаа эсэхэд хяналт тавих бөгөөд Сангийн нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэл өгөх зэрэг үйл ажиллагааг давхар хийж гүйцэтгэх үүрэгтэй тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд юм.

Сангийн кастодианаар "Голомт Банк" ХХК-ийн Кастодиан банкны хэлтэс ажиллах ба уг кастодиан нь 2015 оны 9 сарын 24-ний өдөр албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн, харилцагчийн үнэт цаас, санхүүгийн бусад хөрөнгийг найдвартай хадгалж, өмчлөх эрхийг баталгаажуулах, үнэт цаасны төлбөр тооцоо, компанийн үйл ажиллагаа, орлого цуглуулалт, татварын тооцоолол зэрэг хөрөнгийн зах зээлийн арилжааны дараах мэргэшсэн цогц үйлчилгээг бүрэн хэмжээгээр үзүүлж ажилладаг компани болно. Тус кастодиан нь доорх үйлчилгээг Санд үзүүлэх болно. Үүнд:

- Сангийн хөрөнгийг хадгалах;
- Нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлөх;
- Нэгж эрхийн цэвэр үнэ цэнийг тооцох;
- Тайлан мэдээ гаргах;
- ХОМК-ийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээнд заасан бусад үйлчилгээ.

Сан нь кастодианаас үйлчилгээ авсны хариуд төлбөр шимтгэл төлөх ба уг төлбөр шимтгэлийг талууд Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээгээр тохиролцох боловч ХОМК болон кастодианы үйлчилгээний зардлуудын жилийн нийлбэр дүн нь Сангийн тухайн жилийн активын дундаж үлдэгдлийн гурван (3%) хувиас хэтрэхгүй байна.

Кастодиан нь дараах эрх эдэлж, үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Өөрийн үүргийг биелүүлэхийн тулд Сангаас холбогдох хууль, журамд заасан мэдээлэл, баримт бичгийг тухай бүр шаардаж авах эрхтэй;
- Сан болон ХОМК-ийн Кастодианд ирүүлсэн аливаа хүсэлт, даалгавар, зааварчилгаа нь холбогдох хууль, журам, дүрэм, гэрээний заалтыг зөрчихөөр байвал Кастодиан биелүүлэхээс татгалзах эрхтэй;
- холбогдох хууль, дүрэм, журам, хөрөнгө хадгалах гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэх үүрэгтэй;
- Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй;
- Сангийн дүрэм, журам, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах ба зөрчил илэрвэл эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй;
- Санд холбогдох тайланг заасан давтамжийн дагуу, бусад холбогдох мэдээллийг Сангийн шаардсаны дагуу хүргүүлэх үүрэгтэй;
- Сан болон Сангийн нэгж эрх эзэмшигчдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах үүрэгтэй;



- Сангийн хөрөнгөтэй холбоотой уусч болзошгүй зах зээлийн болон ~~валютын~~ ханшийн эрсдэлийг кастодиан хариуцахгүй;
- Кастодиан нь хөрөнгө хадгалах тэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхдээ холбогдох хууль, дүрэм, журмыг удирдлага болгох ёстой бөгөөд уг үүргээ биелүүлээгүйн улмаас үүсэх сөрөг үр дагавар, хохирлыг Сан хариуцахгүй.

### 3.3.5.2 Эрх бүхий байгууллага

Санг үүсгэн байгуулахаас эхлээд хөрөнгө татан төвлөрүүлэх, хөрөнгө оруулалт хийх бүхий л үйл ажиллагаанд дээрээс хяналт тавих, зохицуулах эрх бүхий байгууллагууд нь Санхүүгийн Зохицуулах Хороо, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК, Улсын бүртгэлийн газар зэрэг бөгөөд эдгээр нь аливаа нэгэн гэрээ хэлцэл, тусгай нөхцөлгүйгээр хуулийн хүрээнд хөндлөнгийн хяналт тавих бүрэн эрхтэй хөндлөнгийн хяналтын бүтэц юм.

## 3.4 УЙЛ АЖИЛЛАГААНДАА БАРИМТЛАХ БОДЛОГО

### 3.4.1 Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

ХОМК нь сонирхлын зөрчил байгаа эсэхийг олж тогтоох, хэрэв сонирхлын зөрчлөөс зайлсхийх боломжгүй бол Сан болон нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэх, тэдний эрх ашиг хөндөгдөхгүй байх бодлого баримтлан ажиллана.

Сангийн ердийн бизнес үйл ажиллагааны хүрээнд Сан болон ХОМК-ийн хооронд сонирхлын зөрчил бий болох магадлалтай хэдий ч тэр тохиолдолд ХОМК нь тухайн сонирхлын зөрчлийг шударгаар шийдвэрлэх ёстой. ХОМК нь Сангийн хөрөнгийг удирдан зохион байгуулахдаа Сангийн эрх ашгийн төлөө хараат бусаар хэлцэл хийнэ.

ХОМК нь тухайн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, хэлцэлд сонирхлын зөрчил байна гэж үзвэл энэ талаар Сангийн ТУЗ-д бичгээр мэдэгдэнэ.

### 3.4.2 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай

Сан нь хөрөнгө оруулалт татах болон санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахдаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хорооны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дүрэм журмуудыг үйл ажиллагаандаа дагаж мөрднө.

### 3.4.2 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай

Сан нь Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, Сангийн нэгж эрх эзэмшигчдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

## 3.5 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Сангийн Нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Сангийн ТУЗ гаргах бөгөөд Сангийн ТУЗ нь ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргахдаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Сангийн дүрэм болон бусад холбогдох журмыг дагаж мөрднө.

Сангийн хувьд үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу Сангийн орлогоор ногдол ашиг хуваарилахгүй байж болно. Харин энэ тохиолдолд Сан нь ямар шалтгаан, үндэслэлээр ногдол ашиг хувиарахгүй болсноо



2021-06-25

бичгээр Сангийн нэгж эрх эзэмшигчдэд тайлбарлана.



Сангийн ТУЗ нь санхүүгийн жил дууссанас хойш тавин (50) хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэх ба ингэхдээ ногдол ашгийг Сангийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна. Сангийн орлогоос Сангийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргахдаа дор дурдсан нөхцөл хангагдсан тохиолдолд Нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилна. Үүнд:

1. Ногдол ашиг төлсний дараа Сан нь төлбөрийн чадвартай байх;
2. Ногдол ашигт төлсний дараа Сангийн хөрөнгийн хэмжээнь өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;
3. Сангийн холбогдох бүхий л татварыг төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна;
4. Сан нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шалгуур үзүүлэлт, харьцаануудаа хангаж байх.

Сан нь ногдол ашиг хуваарилахдаа дараах арга хэмжээг авна. Үүнд:

1. Ногдол ашиг хуваарилахаас өмнө Сантай холбоотой аливаа зардал, өр төлбөрийг бүрэн төлж, барагдуулсан байна.
2. Сангийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахдаа Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу 5 хувийн, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 10 хувийн албан татварыг суутган хуваарилна;
3. Ногдол ашиг хуваарилах шийдвэрт нэгж эрхэд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй Сангийн нэгж эрх эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг тусгана;
4. Ногдол ашиг үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх эрх бүхий байгууллагаар дамжуулан Сангийн нэгж эрх эзэмшигчдийн дансанд шилжүүлэх зарчмаар ажиллана;
5. Ногдол ашиг хуваарилах талаар болон ногдол ашиг хуваарилсан талаар мэдээ, тайланг холбогдох хууль, журмын дагуу мэдэгдэнэ.

### **3.6 ТАТАН БУУГДАХ ТОХИОЛДОЛД ОРЛОГО ХУВААРИЛАХ БОДЛОГО**

Сан татан буугдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Сангийн Нэгж эрх эзэмшигчид нь дараах дарааллын дагуу Сангийн хөрөнгийг өөрийн эзэмших нэгж эрхийн хэмжээнд хувь тэнцүүлэн авах эрхтэй. Үүнд:

1. Сангийн төлөх татварын өр, төлбөр;
2. Санд үйлчилгээ үзүүлсэн ХОМК болон кастодианаас бусад этгээдэд төлөх төлбөр, шимтгэл, урамшуулал;
3. татан буулгах үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээдэд уг ажиллагаатай холбогдох зардал буюу Санхүүгийн Зохицуулах Хорооноос томилогдсон этгээд татан буулгах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа бол уг этгээдэд олгох ажлын хэлс;
4. хөрөнгөхадгалах гэрээний дагуу кастодианд төлөх үйлчилгээний төлбөр, шимтгэл;
5. ХОМК-ийн үйлчилгээний төлбөр, урамшуулал.

Дээрх дарааллын дагуу хөрөнгө хуваарилсны дараа үлдсэн хөрөнгийг Сангийн нэгж эрх эзэмшигчдэд оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн олгоно.



2021 -06- 25



### 3.7 САНГИЙН ЗАРДАЛ

Сангийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай зардлуудад дараах зардал хамаарна.  
Үүнд:

- (а) Санг үүсгэн байгуулах зардал;
- (б) Сангийн хөрөнгө оруулалт татахтай холбоотой зардал;
- (в) хөрөнгө оруулалтын хэрэгсэл худалдан авах эсхүл зарахтай холбогдон гарах брокерийн үйлчилгээний хөлс болон бусад зардлууд;
- (г) Сангийн татварын зардал;
- (д) Санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй ХОМК-ийн үйлчилгээний төлбөр болон гүйцэтгэлийн урамшуулал;
- (е) Санд хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлж буй кастодианы үйлчилгээний төлбөр, шимтгэл;
- (ё) Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурал хуралдуулах зардал;
- (ж) Сангийн ТУЗ-ийн зардал;
- (з) Сангийн маркетингийн зардал;
- (и) Сангийн хүүний зардал;
- (й) Сангийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг тараах, тайлан мэдээлэл бэлтгэн хүргүүлэх зэрэгтэй холбогдон гарах зардлууд;
- (к) Сангийн аудит, нягтан бодох, болон хууль зүйн үйлчилгээний зардлууд;
- (л) Санг татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлууд;
- (м) Сангийн орлогоос нэгж эрх эзэмшигчдэд орлого хуваарилах зардлууд;
- (н) холбогдох хууль, тогтоомж, болон Сангийн холбогдох журамд заасан бусад зардлууд.

Санг үүсгэн байгуулах зардлын хувьд тавин тэрбум (50,000,000,000₮) төгрөгийг нийтээс татан төвлөрүүлсэн тохиолдолд Хөрөнгө оруулалтын санг үүсгэх байгуулах ажиллагааны нийт төсөв нь нэг тэрбум хоёр зуун хорин таван сая (1,225,000,000₮) төгрөг хүртэлх байхаар тооцоолж байгаа бөгөөд доорх хүснэгтэд үүсгэн байгуулах үйл ажиллагаатай холбогdon гарах зардлыг тооцоолон бичив. Доорх зардлын хэмжээ нь Санг үүсгэн байгуулах зардлын дээд хэмжээ бөгөөд үүнээс бага байх бүрэн боломжтой болно.

*Хүснэгт 12. Зардлын бүтэц*

№	Үүсгэн байгуулах үйл ажиллагаатай холбогdon гарсан зардлууд	Нийт босгох дүнгээс хувиар тооцсон	Зардлын хэмжээ (50 тэрбум төгрөгт ногдохоор)
1	"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн бүртгэлийн хураамж	1%	500,000,000₮
2	Зуучлал	1%	500,000,000₮
3	Хуулийн үйлчилгээний зардал	0.075% - 0.3%	75,000,000₮
4	Бусад зардал	0.3%	150,000,000₮
	<b>Нийт</b>	<b>2.375% - 2.6%</b>	<b>1,225,000,000₮</b>

ХОМК болон кастодианы үйлчилгээний зардлуудын жилийн нийлбэр дүн тухайн жилийн активын дундаж үлдэгдлийн гурван (3%) хувиас хэтрэхгүй байна.



Сангийн жилийн нийт зардал нь Сангийн тухайн жилийн активын дундаж үлдэгдлийн таван (5%) хувиас хэтрэхгүй байна. Харин Сангийн тухайн жилийн хөрөнгө оруулалтын хэмхээнээс хамаараад зайлшгүй шаардлага үүссэн гэж ХОМК үзвэл Сангийн нэгж эрх эзэмшигчдийн шийдвэрээр Сангийн зардлын дээд хэмжээнд өөрчлөлт оруулж болно.

### 3.8 TATBAP

Энэхүү хэсэг нь Сан болон хөрөнгө оруулагчдад татварын зөвлөгөө өгөх зорилготой биш бөгөөд зарим тохиолдолд татварын асуудлыг тухайн нэхцэл байдлаас хамаараад татварын тусгай нэхцэл журмаар зохицуулах боломжтой. Иймээс хөрөнгө оруулагч болон ирээдүйн хөрөнгө оруулагчид нь өөрийн оршин байгаа, үүсгэн байгуулагдсан эсхүл иргэншилтэй улс орны хууль тогтоомжийн дагуу Сангийн нэгж эрхийг худалдан авах, эзэмших, худалдах, шилжүүлэх эсхүл аливаа бусад хэлбэрээр захиран зарцуулахтай холбоотойгоор ногдуулах татвар болон түүнээс үүдэн гарах татварын асуудлын талаар өөрийн татварын зөвлөхтэй зөвлөлдөж, илүү дэлгэрэнгүй зөвлөгөө мэдээллийг авахыг зөвлөж байна.

Сан нь Монгол Улсын “Татварын ерөнхий хууль”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хууль болон татварын бусад хууль тогтоомжийн зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, татвар төлнө.

Сан нь хуулийн этгээдийн эрх зүйн байдал, зохион байгуулалтын болон татварын дэглэмийн тухайд онцлог зохицуулалттай байх тухай "Хөрөнгө оруулалтын сангийн тухай" хуульд заасан боловч одоогийн байдлаар хөрөнгө оруулалтын сангийн хувьд тусгай зохицуулалт байхгүй бөгөөд дараах албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, хувь хэмжээг тогтоох ерөнхий зохицуулалт үйлчилнэ. Гэхдээ энэхүү ерөнхий зохицуулалт нь хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт орвол өөрчлөгджэй болохыг анхаарна уу.

Сангийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахдаа "Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулийн дагуу таван (5%) хувиар албан татварыг, "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн дагуу арван (10%) хувиар албан татварыг, Монгол Улсад байрладаг албан татварт төлөгчөөс Монгол Улсад байрладаггүй албан татварт төлөгчид олгосон ногдол ашгийн орлогод хорин (20%) хувиар сүтгэн хуваарилна.

### **3.9 САНД ХӨРӨНГӨ ТАТАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Санд нийт 50 тэрбум хүртэлх төгрөгийг нийтээс татаан төвлөрүүлэхээр төлөвлөж байна

**Анхдагч зах зээлийн арилжааны арга: Тогтоосон унийн аргачлал**

**Арилжаа эрхлэх байгууллага: "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК**

### **3.10 САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Сан нь 2021 оны 6 болон 7-р дугаар сард нийт 50 тэрбум хүртэлх төгрөг татан төвлөрүүлэхээр ажиллаж байна. 8-р сараас зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэлд Сангийн нийт хөрөнгийн 25 хувь хүртэлх хөрөнгө оруулах болон 2021 оны 9 болон 10-р сард шинээр нээлттэй болж буй томоохон компаниудын анхдагч зах зээлийн арилжаанд оролцооор төлөвлөж байна. Сангийн хөрвех чадварыг хангах зорилгоор 5 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөийн төгрөгийн мөнгө

2021 -06- 25

СЭХ  
2021 06. 23 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

байршуулахаар төлөвлөсөн болно.

**Хугацаа:** Сан нь 2021 оны хагас жилээс 2031 оны хагас жил хүртэл үйл ажиллагаа явуулахаар санхүүгийн төсөөлөл гүйцэтгэлээ.

**Эхлэлтийн хөрөнгийн хэмжээ:** 50 тэрбум төгрөг (Зах зээлийн эрэлт дээр үндэслэн хөрөнгийн дүн үүнээс бага байх боломжтой)

Хүснэгт 13. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл /сая.төг/

Санхүүгийн байдлын тайлан	2021	2022	2023	2024	2025	2025	2027	2028	2029	2030	2031
<b>Хөрөнгө</b>											
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,851	3,258	3,745	4,304	4,947	5,687	6,536	7,513	8,636	9,926	10,752
Хөрөнгө оруулалт	53,899	61,898	71,147	81,778	93,998	108,045	124,190	142,748	164,080	188,599	204,280
Хувьцаа	39,715	45,609	52,424	60,258	69,262	79,612	91,509	105,183	120,901	138,967	150,522
Өрийн хэрэгсэл	14,184	16,289	18,723	21,521	24,736	28,433	32,682	37,565	43,179	49,631	53,758
<b>Нийт хөрөнгө</b>	<b>56,736</b>	<b>65,155</b>	<b>74,891</b>	<b>86,082</b>	<b>98,946</b>	<b>113,731</b>	<b>130,727</b>	<b>150,261</b>	<b>172,715</b>	<b>198,525</b>	<b>215,031</b>
<b>Өр төлбөр</b>											
Богино хугацаат өр төлбөр											
Хойшлогдсон татварын өр	567	1,187	1,896	2,711	3,648	4,725	5,963	7,386	9,021	10,901	11,095
<b>Нийт өр төлбөр</b>	<b>567</b>	<b>1,187</b>	<b>1,896</b>	<b>2,711</b>	<b>3,648</b>	<b>4,725</b>	<b>5,963</b>	<b>7,386</b>	<b>9,021</b>	<b>10,901</b>	<b>11,095</b>
Хувь нийлүүлсэн хөрөнгө	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000
Хуримтлагдсан ашиг	6,168	13,969	22,995	33,371	45,298	59,007	74,764	92,876	113,694	137,623	153,937
<b>Нийт цэвэр хөрөнгө</b>	<b>56,168</b>	<b>63,969</b>	<b>72,995</b>	<b>83,371</b>	<b>95,298</b>	<b>109,007</b>	<b>124,764</b>	<b>142,876</b>	<b>163,694</b>	<b>187,623</b>	<b>203,937</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө</b>	<b>56,736</b>	<b>65,155</b>	<b>74,891</b>	<b>86,082</b>	<b>98,946</b>	<b>113,731</b>	<b>130,727</b>	<b>150,261</b>	<b>172,715</b>	<b>198,525</b>	<b>215,031</b>

Сангийн үйл ажиллагаа нь өмчлөлийн үнэт цаас /хувьцаа/ болон хүүний орлогоос бүрдэнэ. Хувьцааны орлого нь тухайн хувьцааны үнэ цэнийн өсөлтөөс болон хөрөнгө оруулсан хувьцааны ногдол ашгаастуст тус бүрдэнэ. Хүүний орлого нь өрийн хэрэгсэл болон харилцах, хадгаламжийн хүүний орлого гэсэн 2 сувгийн нийлбэр юм.

Сангийн үйл ажиллагаатай холбоотой Хөрөнгө оруулалтын менежментийн зардал, Кастодиан үйлчилгээний зардал, Аудитын зардал болон бусад зардлууд нь жил бүр гарна гэж төлөвлөж байна. Хөрөнгө оруулалтын менежментийн зардал болон Кастодиан үйлчилгээний зардал нь цэвэр хөрөнгийн үнэлгээний өсөлт өндөр үед нийт сангийн 3 хувиас хэтрэхгүйгээр төсөөлөл хийсэн болно.

Хүснэгт 14. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн зардал/сийтэг  
2021/06/25

Орлогын дэлгэрэнгүй тайлан	12/21	12/22	12/23	12/24	12/25	12/26	12/27	12/28	12/29	12/30	6/31
Хувьцааны орлого	8,783	8,519	9,783	11,245	12,926	14,857	17,077	19,629	22,563	25,934	14,905
Бодит үнэ цэнийн өсөлтийн олз, гарз	8,783	8,519	9,783	11,245	12,926	14,857	17,077	19,629	22,563	25,934	14,905
Ногдол ашиг											
Хүүний орлого	550	1,787	2,150	2,471	2,841	3,265	3,753	4,314	4,959	5,700	6,551
Өрийн хэрэгсэл	523	1,702	2,052	2,359	2,712	3,117	3,583	4,118	4,733	5,441	6,254
Харилцах	26	85	98	112	129	148	171	196	225	259	298
Нийт үйл ажиллагааны орлого	9,333	10,306	11,934	13,717	15,766	18,123	20,831	23,943	27,521	31,634	21,456
ХОМК-ийн үйлчилгээний зардал	914	1,588	1,821	2,093	2,405	2,765	3,178	3,653	4,199	4,826	3,161
Кастодиан үйлчилгээний зардал	60	114	134	154	177	203	234	269	309	355	204
Аудитын зардал	359	57	67	77	88	102	117	134	154	178	102
Бусад зардал	552	568	670	770	885	1,017	1,169	1,344	1,545	1,776	1,020
Хөрөнгө босгохтой холбоотой зардал	1,225	-	-	-	-	-	-	-	-	-	-
МХБ бүртгэл	500										
Зуучлал	500										
Хуулийн зардал	75										
Сан байгуулах бусад зардал	150										
Нийт үйл ажиллагааны зардал	3,109	2,327	2,692	3,094	3,556	4,087	4,698	5,400	6,207	7,135	4,488
Татварын өмнөх ашиг	6,223	7,979	9,242	10,623	12,211	14,035	16,133	18,543	21,314	24,499	16,968
Татварын зардал	55	179	215	247	284	327	375	431	496	570	655
Татварын дараах ашиг	6,168	7,801	9,026	10,376	11,927	13,709	15,757	18,112	20,818	23,929	16,313
Хойшлогдсон татвар	567	619	709	815	937	1,077	1,238	1,423	1,636	1,880	193

Санг байгуулах, хөрөнгө босгохтой холбоотой нэг удаагийн шинж чанартай зардал 2021 оны 6 болон 7 дугаар сард гарахаар төлөвлөж байна. "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн бүртгэл, үйлчилгээний хөлс, хуулийн үйлчилгээний зардал, нэгж эрхийг олон нийтэд танилцуулах, хөрөнгө татан төвлөрүүлэх болон энд дурдагдаагүй сан байгуулахтай холбоотой бусад зардууд нь нэг удаа буюу 2021 онд гарахаар төлөвлөж байна.

## 4. “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

Сан нь нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000,000 ширхэг хүртэлх нэгж эрх гаргаж, үүний 95 хувь буюу 47,500,000 ширхэг хүртэлх нэгж эрхийг олон нийтэд нээлттэй санал болгохоор төлөвлөсөн. Хөрөнгө оруулагчид өөрийн нэр дээрх харилцагч үнэт цаасны компаниар дамжуулан анхдагч болон хоёрдогч зах зээлээс нэгж эрхийг худалдан авах боломжтой.

Нэгж эрх гаргагч	“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын хөрөнгө оруулалтын сан	
Нэгж эрхийн хэлбэр	Биет бус	
Нэгж эрхийн нэрлэсэн үнэ	1,000 төгрөг	
Олон нийтэд санал болгож буй нэгж эрх		
▪ Нэгж эрхийн тоо	= 47,500,000 хүртэлх	
▪ Нийт нэгж эрхэд эзлэх хувь	= 95%	
Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	47,500,000,000 төгрөг хүртэлх	
Хөрөнгө оруулалтын хэлбэр	Зөвхөн мөнгөн хөрөнгөөр	
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт	Хөрөнгө оруулалт	
Санал болгох хүрээ	Олон нийт	
Нэгж эрх санал болгох арга хэлбэр	Тогтсон үнийн арга	
Арилжааг зохион байгуулах байгууллага	“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК	
ХОС үүсгэн байгуулагч	“Мандал Ассет Менежмент УЦК” ХХК	

### 4.1 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

№	Нэгж эрх эзэмшигчдийн нэр	Одоо (Олон нийтэд санал болгохын өмнө)		Дараа (Олон нийтэд санал болгосны дараа)	
		Гаргасан нэгж эрхийн тоо	Эзлэх хувь	Гаргасан нэгж эрхийн тоо	Эзлэх хувь
1	“Мандал Ассет Менежмент УЦК” ХХК	100	100%	2,500,000	5%
2	Олон нийт	-	-	47,500,000	95%
	Нийт	100	100	50,000,000	100%



## 4.2 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧИД БОЛОН ТЭДГЭЭРИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Санд хувь хүн, хуулийн этгээд хөрөнгө оруулж, нэгж эрх эзэмшигч болох боломжтой. Сангийн нэгж эрх эзэмшигчид нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

- (1) Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- (2) Сангийн ТУЗ-өөс тогтоосон хэмжээгээр өөрийн хөрөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн ногдол ашиг хүртэх;
- (3) бусад Сангийн нэгж эрх эзэмшигчдийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа нэгж эрхээ чөлөөтэй захиран зарцуулах;
- (4) Санг татан буугдах үед өөрт ногдох хөрөнгийг хүлээн авах;
- (5) Сангийн нэгж эрх эзэмшигч нь Сангаас нэмж гаргаж байгаа нэгж эрхээс өөрийн эзэмшиж буй хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх;
- (6) Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах хүсэлтийг Сангийн менежер, Сангийн ТУЗ-д гаргах;
- (7) ХОМК, кастодианы үйл ажиллагааг зогсоох, түүнийг өөрчлөх тухай асуудлыг Сангийн ТУЗ эсхүл Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх санал гаргах;
- (8) Сангийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
- (9) өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа нэгж эрхийн тоог нэгж эрх эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх;
- (10) Сангийн өр төлбөр, бусдаас авсан зээлийг нэгж эрх эзэмшигч өөрийн хөрөнгөөр хариуцахгүй;
- (11) Сангийн нэгж эрх эзэмшигч өөрийн нэгж эрхийн төлбөрийг төлсөний дараа аливаа төлбөр хийх үүрэг хүлээхгүй;
- (12) Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

## 4.3 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛАН ХҮРГҮҮЛЭХ

Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хуралд мэдээлэх мэдээлэл нь Сангийн дотоод мэдээлэлд хамаарна. Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд дараах мэдээллийг мэдээлнэ. Үүнд:

- (1) Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын болон жилийн тайлан;
- (2) ХОМК-ийн үйл ажиллагааны тайлан;
- (3) Сангийн менежерийн эрсдэлийг тооцоолсон тооцоолол;
- (4) Кастодианы үйл ажиллагааны тайлан, дансны хуулбар;
- (5) үнэлгээчин, брокер, дилертэй байгуулсан гэрээ, танилцуулга;
- (6) дотоод хяналтын хорооны дүгнэлт.



## 5. “МАНДАЛ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК” ХХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

### 5.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021 -06- 25

БҮРТГЭВ-03

Нэр

“Мандал Ассет Менежмент УЦК” ХХК

Компанийн хэлбэр

Хязгаарлагдмал  
компани

Регистрийн дугаар

5497418

Улсын бүртгэлийн дугаар

9011298077

Үйл ажиллагааны чиглэл

Хөрөнгө оруулалтын менежмент

Үйл ажиллагаа явуулах хугацаа

Хугацаагүй

Цорын ганц хувьцаа эзэмшигч

“Мандал Санхүүгийн Нэгдэл” ХХК

Гүйцэтгэх захирал

Ганбатын Ганзориг

Хаяг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р  
хороо, Жамъян-Гүний гудамж, Меру  
тауэр-602 тоот

Санд эзэмших нэгж эрхийн хувь  
хэмжээ

5%

ХОМК нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн №97 дугаар тогтоолоор олгосон ТЗ 309/30 дугаартай “Үнэт цасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд юм. ХОМК нь 2021 онд “Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулж дотоодын зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг томоохон хувьцаат компаниудын хувьцаа болон үнэт цасанд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.

#### Алсын хараа:

Хөрөнгө оруулалтын менежментийн хамгийн итгэлтэй мэргэжлийн компани байх

#### Эрхэм зорилго:

Хөрөнгө оруулагчиддаа урт хугацаанд тогтвортойгоор үнэ цэнэ өгөөжийг хүртээх

#### ХОМК-ийн философи:

Нэгдүгээрт – Мэргэжлийн ёс суртахуун: Санхүүгийн байгууллагын хувьд бид бүхий л үйл ажиллагаандaa шударга, сахилга баттай байхыг зорьдог. Түүнчлэн манай байгууллагын ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагаандaa ёс суртахууны хэм хэмжээг дээд зэргээр мөрдөж ажиллахыг эрхэм болгодог.

Хоёрдугаарт – Эрсдэлийн удирдлага: ХОМК нь эрсдэлээс сэргийлэх соёлыг нэн тэргүүнд тавьж, ажиллагсад өдөр тутмын ажилдаа эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэвшүүлдэг.

Гуравдугаарт – Хөрөнгө оруулалтын өгөөж: Бид өөрийн хөрөнгө оруулагчдаа оновчтой багц бүрдүүлэхэд нь тусалж урт хугацааны эрсдэлгүй өгөөж хүртээхэд туслах зорилготой.



## 5.2 УДИРДЛАГА, КОМПАНИЙН БҮТЭЦ

МОНГОЛЫН ХЕРЭНТИЙН БҮТЭЦ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-06-25



ХОМК нь олон улсын эрсдэлийн удирдлага болон компанийн засаглалын арга барилыг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлж урт хугацаанд өндөр өгөөж өгдөг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээр багцаа бүрдүүлж ажилладаг. Мэргэжлийн ёссуртахууныг эрхэм болгон мэргэшсэн туршлагатай баг Компанийн үйл ажиллагааг удирдан явуулдаг.

Зураг 10. "Мандал Ассет Менежмент УЦК" ХХК-ийн бүтэц



"Мандал Санхүүгийн Нэгдэл" ХХК нь ХОМК-ийн 100% хувийн хувьцааг дангаар эзэмшдэг цорын ганц хувьцаа эзэмшигч юм. 2010 онд байгуулагдсан "Мандал Санхүүгийн Нэгдэл" ХХК нь даатгал, хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалтын менежмент, эрсдэлийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монголын тэргүүлэх санхүүгийн байгууллага юм. "Мандал Санхүүгийн Нэгдэл" ХХК нь 2021 оны байдлаар дараах компаниудад хувьцаа эзэмшдэг. Үүнд:

- "Мандал Даатгал" ХК
- "Мандал Ассет Менежмент УЦК" ХХК
- "Эм Ай Би Жи УЦК" ХХК
- "Ганзориг Бизнес Скуул" ХХК
- "Мандал Риск Менежмент" ХХК

2021 -06- 25

## 5.3 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ХОМК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ХОМК-ийн ТУЗ") нь Згишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд улиралд нэгээс доошгүй хуралддаг, хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага юм.

№	ХОМК-ийн ТУЗ-ийн гишүүдийн нэр	Албан тушаал	Мэргэжил
1.	Ө.Ганзориг	ХОМК-ийн ТУЗ-ийн дарга	Эдийн засагч
2.	Н.Монсор	ХОМК-ийн ТУЗ-ийн гишүүн	Санхүүч
3.	Г.Гантулга	ХОМК-ийн ТУЗ-ийн гишүүн	Нягтлан бодогч

**ХОМК-ийн ТУЗ-ийн дарга: Ө.Ганзориг**

Ө.Ганзориг анх банкны дилерээр ажлын гараагаа эхэлснээс хойш 20 гаруй жил банк, даатгал, хөрөнгийн зах дээр ажилласан туршлагатай хөрөнгө оруулагч, эдийн засагч юм. Ө.Ганзориг нь Хас Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Тэнгэр Даатгал, Улаанбаатар Хотын Банканд удирдах алба, Санхүүгийн зах зээлийн холбооны Ерөнхийлөгч, Монголын банкуудын холбооны Ерөнхийлөгч, Монголын даатгагчдын холбооны Дэд ерөнхийлөгч, Голомт банкны Гүйцэтгэх захирлын албыг хашиж ирсэн туршлагатай эдийн засагч юм. Мөн "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн ТУЗ-н гишүүн, Монгол банкны Мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий Сайдын дэргэдэх эдийн засагчдын зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж ирсэн. Тэрээр Мандал даатгалын үүсгэн байгуулагч бөгөөд ТУЗ-ын даргын албыг хашиж байна.

**ХОМК-ийн ТУЗ-ийн гишүүн Н.Монсor**

Н.Монсor нь хил дамнасан хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр олон жилийн туршлага хуримтлуулсан туршлагатай санхүүч. Тэрээр өнгөрсөн хугацаанд олон улсын томоохон хөрөнгө оруулалтын сангүүдтай хамтран ажиллаж, Монгол улсын үл хөдлөх хөрөнгө, санхүү, худалдааны салбаруудад олон арван тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татаж чаджээ. Н.Монсor нь ХОМК-ийн ТУЗ-н гишүүн, Улаанбаатар Ассет Менежментийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тэрээр программ хангамжийн бакалавр зэрэгтэй юм.

**ХОМК-ийн ТУЗ-ийн гишүүн Г.Гантулга**

Г.Гантулга нь ХОМК-ийн ТУЗ-н гишүүн бөгөөд СЭЗИС-н ОУНББСМС-ийн захирлаар ажилладаг. Өмнө нь тэрээр ЭМОН ХХК-д багш, тэнхимиийн эрхлэгч, ХУДС-д багшаар ажиллаж байсан туршлагатай. Г.Гантулга нь 2002 онд ХУДС Нягтлан бодогч бакалавр, 2004 онд ХУДС Бизнесийн удирдлага, 2015 онд СЭЗИС Бизнесийн удирдлагын магистр зэргээ тус тус хамгаалсан байна.



2021 -06- 25

БҮРТГЭВ-03

СЭХ  
он 2021 сар 06 23  
БҮРТГЭВ № 01

#### 5.4 ДОТООД ХЯНАЛТЫН АЛБА

Дотоод хяналтын алба ("ДХА") нь ХОМК-ийн уйл ажиллагааг холбогдох хууль журмын хүрээнд явуулж байгаа эсэхэд хяналт тавьж, үйл ажиллагааны дүгнэлтээ ХОМК-ийн ТУЗ-д тайлagnадаг нэгж юм. Энэхүү нэгж нь ээлжит болон ээлжит бус шалгалтыг компанийн санхүү, хөрөнгийн удирдлага, дотоод үйл ажиллагаа гэсэн чиглэлүүдээр төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг. Дотоод хяналтын алба нь 3 гишүүнтэй байх бөгөөд аудитын үйл ажиллагаа явуулах эрх авсан, тус чиглэлийн туршлагатай болно.

№	Удирдлагын нэр	Албан тушаал	Мэргэжил
1	Г. Гантулга	ДХА-ны дарга	Нягтлан бодох бүртгэл
2	Б. Энхтувшин	ДХА-ны гишүүн	Санхүүч
3	Б. Баттушиг	ДХА-ны гишүүн	Хуульч

#### ДХА-ны дарга: Г. Гантулга

Г. Гантулга нь СЭЗИС-ийн ОУНББСМС-ийн захирлаар ажилладаг. Өмнө нь тэрээр ЭМОН ХХК-д багш, тэнхимиийн эрхлэгч, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуульд багшаар ажиллаж байсан туршлагатай. Г. Гантулга нь 2002 онд Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийг нягтлан бодогч мэргэжлээр бакалаврын зэрэгтэйгээр төгсөж, 2004 онд ХУДС Бизнесийн удирдлага, 2015 онд СЭЗИС Бизнесийн удирдлагын магистр зэргээ тус тус хамгаалсан байна.

#### ДХА-ны гишүүн: Б. Энхтувшин

Б. Энхтувшин нь Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар ажилладаг. Тэрээр өмнө нь банк санхүүгийн салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд гадаад төлбөр тооцооны албаны дарга, нөөцийн газар болон санхүүгийн газрын захирлаар тус тус ажиллаж байсан. Б. Энхтувшин нь Монгол Улсын Их сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр, магистрын зэрэгтэйгээр тус тус төгссөн.

#### ДХА-ны гишүүн: Б. Баттушиг

Б. Баттушиг нь өмгөөллийн ДиБи энд ЖиTiЭс ХХН-н партнераар ажилладаг. Тэрээр өмнө нь төслийн санхүүжилт, дотоод болон олон улсын хөрөнгийн зах зээл, сэргээгдэх эрчим хүчиний төслүүд болон уул уурхайн томоохон хэлцлүүдэд хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай. АНУ-н Дикенсин их сургуульд бакалавр, Чикаго-Кент коллежийн хууль зүйн сургуулийг Juris Doctor зэрэгтэй төгссөн.

УЛААНБААТАР ХОТ

МАНДАЛ  
ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ  
ХАМТЫН ХОС  
ХХК



9021060636 № 6702988

2021 -06- 25

## 5.5 МЕНЕЖМЕНТИЙН БАГ

ХОМК-ийн гүйцэтгэх албаны эдийн засаг, санхүү болон хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн туршлагатай бөгөөд судалгаа шинжилгээ боловсруулах, хөрөнгө оруулалтын стратеги тодорхойлох болон зах зээлд хөрөнгө оруулалт хийх замаар хөрөнгийн үнэ цэнийг бий болгоход анхааран ажиллаж байна.

Одоогоор ХОМК нь 7 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.



№	Нэр	Албан тушаал	Мэргэжил	Боловсрол
1	Г.Ганзориг	Гүйцэтгэх захирал	Эдийн засагч	Монгол улс, СЭЗИС, Санхүү удирдлага, Бакалавр, Англи улс, Лийдс Их Сургууль, Эдийн засаг, Магистр
2	Д.Баатаржав	Дэд захирал	Санхүүч	Монгол улс, СЭЗИС, Санхүү удирдлага, Бакалавр, АНУ, Бриджпорт их сургууль, Санхүү удирдлага, Магистр
3	Б.Батхишиг	Дэд захирал	Эдийн засагч	Монгол улс, СЭЗИС, Бизнесийн эдийн засагч, Бакалавр Унгар улс, Мишкольц их сургууль, Бизнесийн удирдлага, Магистр



Гүйцэтгэх захирал: Г.Ганзориг

Г.Ганзориг нь ХОМК-ийн гүйцэтгэх захирал бөгөөд хөрөнгө оруулалт, санхүү болон үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Тэрээр өмнө нь Мандал Даатгал компанийн хөрөнгө оруулалт хариуцсан захирал, Голомт Банкны ахлах макро эдийн засагч, Юу Эм Си Альфа болон Мандал Даатгал компанийн санхүүгийн шинжээчээр тус тус ажиллаж байсан. Тэрээр Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг санхүүгийн удирдлагын бакалавр, Английн Лийдсийн их сургуулийг эдийн засгийн ухааны магистр зэргээр дүүргэсэн.



2021 -06- 25

СЭХ  
2021. 06. 23 өдөр  
**БҮРТГЭВ**  
№ 01



### Дэд захирал: Д.Баатаржав БҮРТГЭВ-03

Д.Баатаржав нь ХОМК-ийн дэд захирал бөгөөд өмнө нь хөрөнгө оруулалтын банк, хөрөнгө оруулалтын багцын удирдлагаар Тэнгэр Санхүүгийн Нэгдэл, Юу Эм Си Альфа, Мандал Даатгалд ажиллаж байсан туршлагатай. Өмнө нь алт, үл хөдлөх хөрөнгө, ноолуур, зочид буудал, ББСБ, даатгал, эмнэлэг, мах боловсруулах болон шилэн кабелийн сүлжээний салбарын томоохон төслүүдэд хөрөнгө оруулалт татах болон хөрөнгө оруулалт хийж байсан туршлагатай. Тэрээр Санхүү Эдийн Засгийн Их сургуулийн санхүү удирдлагын бакалавр, АНУ-ын Брижпортын их сургуулийг санхүүгийн чиглэлээр магистр зэрэгтэй.



### Дэд захирал: Б.Батхишиг

Б.Батхишиг нь Мандал Ассет Менежмент ХХК-н дэд захирал бөгөөд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Тэрээр Мандал даатгалд актуар эрсдэлийн удирдлага, Ньюком группт санхүүгийн төлөвлөлт, DZ group-т санхүү, хөрөнгө оруулалтын зөвлөх үйл ажиллагааны чиглэлээр ажиллаж байсан туршлагатай. Б.Батхишиг нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг Бизнесийн эдийн засагч мэргэжлээр бакалавр, Унгар улсын Мишкольц Их Сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн.

## 6. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Эрсдэл гэдэг нь компани зорилго, зорилтдоо хүрэхэд учрах тодорхой бус байдал, үр дагавар, гарз хохирлыг ойлгоно. Сангийн гол эрсдэл нь хөрөнгийн үнэ цэнийн бууралт юм. Компанийн үйл ажиллагаанд болон удирдаж буй Сангийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүрдүүлэх нь компанийн засаглалын болон хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөлийн нэг болно.

Сангийн нэгж эрх эзэмшигч нь Сангийн эрсдэлийн удирдлагын аргачлалыг хэрхэн хэрэгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагаагаа эрсдэлгүй ажиллах эсэхэд анхаарч судлах нь зүйтэй.

Сан нь хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн санхүүжилтээр үнэт цаасны хөрөнгө оруулалтын арилжаа хийх тул нийгэм эдийн засаг, санхүү болон үйл ажиллагааны эрсдэлүүдийг удирдах шаардлага тулгарах юм. Тиймээс компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, тодруулбал ажилтан болон алба бүрийн, удирдаж буй сангийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах асуудлыг өдөр тутмын үйл ажиллагаанд ямагт анхаардаг байх нь эрсдэлийг оновчтой удирдах гол аргачлалын нэг гэж үзнэ.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийн удирдлагын зорилтуудаа тодорхойлох, эрсдэлийг тодорхойлох, үнэлэх эрэмбэлэх, хариу арга хэмжээг сонгох болон эрсдэлийг удирдах бууруулах гэсэн үндсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ. Үүнд:




## БҮРТГЭВ-03



- (1) Эрсдэлийн удирдлагын зорилтуудаат тодорхойлох: энэ шат нь бизнес төлөвлөлтийн чухал бүрэлдэхүүн юм. Эрсдэлийн удирдлага нь компанийд учирч болох нөхцөл байдлуудыг тодорхойлж үүний эсрэг төлөвлөлт хийх боломжтой болгодог. Мөн зорилт тодорхойлох гол бүрдэл нь эрсдэлд тэсвэрлэх чадамжийг /risk tolerance / тооцдог.
- (2) Эрсдэлийг тодорхойлох, олжтоогоо: энэ шат нь Сангийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц бүх л төрлийн эрсдэлийг тодорхойлж, хөрөнгө эсвэл үйл ажиллагааны гүйцэтгэлд хэр зэрэг нелөө үзүүлж болохыг тодорхойлно.
- (3) Эрсдэлийгүнэлэх, эрэмбэлэх: энэ шат нь эрсдэлийн хүлээгдэж буй давтамж болон хүлээгдэж буй үр дагаврыг үнэлж эрсдэлийн матрицын дагуу эрэмбэлж үйл ажиллагаандaa тусгаж ажиллана.
- (4) Эрсдэлээс сэргийлэх хариу арга хэмжээг сонгох: энэ шат нь эрсдэлийн удирдлагын дараах шат нь эрсдэл тус бүрт тохирсон хариу арга хэмжээг сонгож тодорхойлно. Хөрөнгө оруулалт эсхүл үйл ажиллагааны эрсдэлийн ангилал тус бүрт тохирсон эрсдэлээс сэргийлэх аргачлалыг үйл ажиллагаандaa тусгана.
- (5) Эрсдэлийг удирдах, бууруулах: энэ шат нь тохиромжтой цаг тухай бүрт нь эрсдэлийг удирдах, бууруулах арга хэмжээг авч ажиллах нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны удаах шат юм. Сангийн дотоод бодлого журам нь эрсдэлийн хариу арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх гол систем бөгөөд хяналтын системийг давхар бий болгодог.

2021-06-25  
НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРАЛ  
БҮРГЭС-03



Эрсдэлийг удирдах дээрх бүтцээр ХОМК нь Сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой бүхий л нөхцөл байдлыг үнэлж дүгнэн Сангийн ТУЗ-тэй хамтран ажиллана. Сангийн үйл ажиллагааны бүх түвшинд эрсдэлийн удирдлагын талаарх ойлголтыг нэвтрүүлэх, ажилтан бүр энэ талын мэдлэгээ тогтмол дээшлүүлж ажиллахыг эрхэмлэнэ. Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн хурал, Сангийн ТУЗ нь шат бүрт хяналт тавьж ажилласнаар засаглалын эрсдэлийг бууруулах боломж бүрдэх юм.

## 6.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРСДЭЛ

Хөрөнгө оруулалтын багцын өгөөжийн хэмжээ буурах, алдагдал хүлээх болон зах зээлийн нөхцөлтэй холбоотойгоор багцад учрах эрсдэлүүд үүнд багтана. Сан нь багцын зорилтот өгөөж гүйцэтгэлийг хянаж учирч болох хөрөнгө оруулалтын эрсдэлүүдийг тооцон ажиллана.

Зах зээлийн эрсдэл: Сангийн удирдаж буй хөрөнгийн үнэлгээ эдийн засаг, улс төр, санхүү болон нийгмийн эрүүл мэндтэй холбоостой (халдварт өвчин, цар тахал гэх мэт) эсхүл зах зээлд өрнөж буй үйл явдлаас шалтгаалан өсөх, буурах зэрэг хэлбэлзэж болно. Дээрх дурьдсан үйл явдлаас шалтгаалсан гэнэтийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах, төсөөлөх нь хүнд сорилт байдаг. Тиймээс Сан нь нийгэм, эдийн засгийн судалгаа шинжилгээнд үндэслэн урт хугацаанд тогтвортой, өндөр өгөөжтэй байх хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийнэ. Нийгэм эдийн засгийн өдөр тутам хувьсан өөрчлөгдөж буй орчинд тохируулан богино хугацаанд хөрөнгө оруулалт ба үйл ажиллагаагаа олонд шийдвэрүүдийг судалгаа шинжилгээнд суурилан гаргаж ажиллана.

2021-06-25

Хөрөнгө оруулалтын хэлбэрийн эрсдэл: Тодорхой зах зээлийн нөхцөлд, хөрөнгө оруулалтын өгөөж нь эдийн засгийн тэлэлт, өсөлтийн үед илүү өндөр байдаг. Тиймээс эдийн засгийн нөхцөлд тохиуулан хөрөнгө оруулалтыг хийх шаардлагатай тулгарна. Сан нь хөрөнгө оруулалтын стратеги, төлөвлөлт баримт бичигт үндэслэн хөрөнгө оруулалтыг аль үед хийх стратеги төлөвлөгөөг цаг тухай бүр өөрчилж шинэчлэх замаар ажиллана.

Хөрвөх чадварын эрсдэл: Зах зээл дэх үнэт цаасны арилжааны хэмжээ нь эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал, хандлагаас хамаарч мэдэгдэхүйц хэлбэлздэг. Тиймээс Сангийн хөрөнгө оруулалт нь зах зээлийн гэнэтийн өөрчлөлт, хөрөнгө оруулагчдын хандлага эсвэл зохицуулагч байгууллагын оролцооны нөлөөгөөр хөрвөх чадвар сүл болох эрсдэл бий. Зах зээлийн хурдан хувьсamtгай нөхцөлд, хөрөнгө оруулсан үнэт цаас худалдан авагчгүй болох эсхүл хөрөнгө оруулалт тохиромжтой цагт, тохиромжтой үнээр зарагдаж чадахгүй байх эсхүл Сан хөрөнгө оруулалтыг бага үнээр зарах нөхцөлд орох эсхүл хөрөнгө оруулалтыг буцаан борлуулж чадахгүй байх зэрэг нь хөрвөх чадварын эрсдэлд багтана. Хөрөнгө оруулалтын хөрвөх чадвар сүл байх нь Сангийн хөрөнгийн үнэ цэнийг бууруулах эсхүл бусад хөрөнгө оруулалт хийх боломжуудыг хаах сөрөг нөлөөтэй.

Хөрвөх чадварын эрсдэлд мөн үнэт цаас гаргагч нь эдийн засаг, салбарын нөхцөл байдлаас шалтгаалан төлбөрийн чадваргүй болох эсхүл төлбөр төлөлт хойшлох зэрэг нь багтдаг. Энэхүү эрсдэлийг бууруулахын тулд үнэт цаас тус бүрт хөрвөх чадварын үнэлгээг тодорхойлж багц бурдүүлэн ажиллах болно. Хөрөнгө оруулалтын багцыг төвлөрөл багатай үнэт цаас, хувьцаа ба бондод тархаан байршуулж эрсдэлээс сэргийлж ажиллана.

Харилцагч байгууллагын эрсдэл: Харилцагч байгууллага нь гэрээнд тусгасан санхүүгийн үүргээ биелүүлэхгүй байх эсхүл төлбөрийн чадваргүй болох эрсдэл юм. Хэрэв харилцагч байгууллага нь санхүүгийн үүргээ хугацаандаа биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Сан багцын өгөөж хүртэж чадахгүй байх, сангийн хөрөнгө буурах зэрэг эрсдэлтэй. Үнэт цаас Гаргагчийн санхүүгийн үзүүлэлтэд шинжилгээ хийх, төлбөрийн чадваргүй болох эрсдэлийг тодорхойлох болон тус компанийн мэргэжлийн байгууллагын хийсэн үнэлгээнд суурилан хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргаж ажиллана.

Багц төвлөрлийн эрсдэл: Сан нь цөөн тооны үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж төвлөрүүлэх нь багцын төвлөрөл нэмэгдэж эрсдэл бий болдог. Зохицуулах байгууллагын журамд тусгаснаар, компанийн хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан багц бурдүүлэлтийн зохистой түвшингхангаж ажиллана. Хөрөнгө оруулалтын бодлого болон журамд тусгаснаар Сангийн хөрөнгө оруулалтын хэмжээ эдийн засгийн аль нэг салбарт 25 хувиас хэтрэхгүй байх ба нэг компанийн хувьцааны 10 хувиас хэтрэхгүй байх дүрэмтэй.

Багцын эрсдэл: Энэхүү эрсдэлд Сангийн багц бурдүүлтэд хамаарах засгийн газар, аймаг нийслэл болон компанийн өрийн хэрэгслийн хувьд гэрээнд заасан хугацаанд төлбөр төлөх чадваргүй болох дефолт буюу төлбөр гүйцэтгэх чадваргүй болох эрсдэл хамаарна. Засгийн газар, төрийн байгууллагын хувьд төлбөр гүйцэтгэх чадваргүй болох эрсдэл туйлын бага байдаг. Компанийн хувьд санхүүгийн чадамжийг нь үнэлж тодорхойлох, барьцаа хөрөнгө гэрээнд тусгах зэргээр тус эрсдэлийг бууруулж ажиллана. Багцад байгаа компанийн хувьцааны үнэлгээ буурах, алдагдалтай ажиллах болон дампуурах эрсдэл байдаг. Энэхүү эрсдэлийг бууруулах зорилгоор компанийн хөрөнгийн болон санхүүгийн үнэлгээг урьдчилан хийж эрсдэл багатай үйл ажиллагаа тогтвортой явуулах боломжтой компанийн хувьцааг сонгож ажиллана.

**Хүүгийн тувшний эрсдэл:** Зах зээл дэх хүүгийн тувшин өөрчлөгдөх нь Сангийн мөнгөн хөрөнгийн хадгаламжийн өгөөжийн тувшинд нөлөөлнө. Иймд хүүгийн тувшний өөрчлөлт таамаглалыг улирал бүр шинэчилж, тогтвортой үйл ажиллагаатай, эрсдэл даах чадвар өндөр банкийг харилцагчаар сонгож ажиллана.

**Инфляцийн эрсдэл:** Сангийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтаас олох өгөөж нь ирээдүйн инфляцийн тувшин, мөнгөний үнэ цэнийн утгаас хамааран бодит утгаараа төлөвлөсөн хэмжээнээс бага байх эрсдэл бий. Инфляцийн өсөлт нь эдийн засгийн бусад хүчин зүйлст нөлөөлөх ба үнэт цаасны бодит үнэ цэнд нөлөөлнө. Сан нь инфляци, эдийн засгийн загварын таамаглал ашиглан ирээдүйн инфляцийн тувшиинг тооцон ажиллана.

**Валютын ханшийн эрсдэл:** Ханшийн хэлбэлзэл нь зах зээлд тодорхой бус байдлыг нэмэгдүүлж эдийн засгийн үйл хөдлөлийн зардлыг ихэсгэдэг. Иймд жил бүр ханшийн таамаглал хийж тус эрсдэлийг тооцон ажиллана.

**Загварын эрсдэл:** Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд багц бүрдүүлэлт, хувьцааны үнэт цаасны шинжилгээ болон хөрөнгө оруулалтын загвар тоон шинжилгээнүүдийг гашиглах үед тооцооллын зөрүү гарах, эсрэг үр дүн үзүүлэх эрсдэл тохиолддог. Тус эрсдэл нь шинжээчийн ур чадвар, тоон өгөгдөл болон ашиглаж буй загвар зэрэг хүчин зүйлсээс шалтгаална. Тиймээс эрсдэлийн удирдлагын бодлогоор ашиглаж буй загвар, тоон шинжилгээнд давхар хяналт хийх, зах зээлийн өөрчлөлттэй холбогдуулан өөрчлөх болон дотоодын болон улсын байгууллагуудтай хамтарч ажиллаж тус эрсдэлийг бууруулахыг зорино.

**Компанийн бондын эрсдэл:** Бонд гаргасан хуулийн этгээд нь гэрээнд тусгагдсан бондын хүү болон үндсэн төлбөрийн үүргээ хэрэгжүүлж чадахгүй байх эрсдэл бий. Сан хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаандаа эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж бонд гаргагч компанийн удирдлагын баг, санхүүгийн чадамж болон төлбөр төлөх чадварыг үнэлж ажиллана.

**Сангийн удирдлага, ажилтны эрсдэл:** Сангийн удирдлага, ажилтны гаргах шийдвэрүүд нь Сангийн хөрөнгийг бууруулах, алдагдал бий болгох эрсдэлтэй. Тус эрсдэлийг бууруулахад Санхүүгийн Зохицуулах Хороо, Сангийн дүрэм, журамд тусгасан Сангийн үйл ажиллагааны журмыг дагаж мөрднө.

## 6.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Сан үйл ажиллагаа явуулахад хүний нөөц, ашиглаж буй систем дотоод дүрэм журам болон зах зээлээс нөлөөлж болохуйц үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүдүнд хамаарна. Жишээлбэл хүнээс хамаарах үйл ажиллагааны алдаа, технологийн доголдол болон хууль эрх зүйтэй холбоотой эрсдэлүүд багтана.

**Технологийн эрсдэл:** Сангийн үйл ажиллагаа нь мэдээлэл технологи, системийн үйл ажиллагаатай нягт холбоо хамааралтай ажиллах учир үйл ажиллагаанд тус чиглэлийн эрсдэл нь чухалд тооцогдоно. Хөрөнгийн багц удирдах, эрсдэл судалгаа тооцоолол болон арилжааны бүхий л үйл ажиллагаа нь мэдээллийн технологийн системээс хамаарах юм. Иймд технологийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, шаардлагатай шийдлүүдийг боловсруулж ажиллана. Мөн Сангийн үйл ажиллагаа нь цахим халдлагад өртөх, үүнээс шалтгаалан дотоод мэдээлэл алдагдах, өгөгдөл мэдээлэл устах болон үйл ажиллагаанд хүндрэл учрах зэрэг эрсдэлүүд бий. Тиймээс цахим халдлага, аливаа холбогдох эрсдэлээс хамгаалах бодлого стратеги боловсруулж Сангийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллана.

Дотоод боллого, журмуудын нийцлийн эрсдэл: Сан нь дотооддоо мөрдөж буй-боллого төлөвлөгөө, дүрэм журам зэрэгт тавигдах шаардлагууд болон бүх нийтээр худээн зөвшөөрсөн засаглалын хяналтын тогтолцоотой холбогдох эрсдэлүүд тус хэсэгт хамаарна. Хууль эрх зүйн хэм хэмжээ ба Сангийн дотоод хяналтын тогтолцоонд мөрдөх үйл явц, хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчлүүдийг зохих хяналтын бүтцэд мэдэгдэх, бие даасан, байнгын ажиллагаатай удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, бодлого журмуудын нийцлийг хангаж ажиллана.

Хууль, эрх зүйн орчны эрсдэл: Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан журмууд болон бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон, шинэчлэн найруулсан эсхүл хүчингүй болсон тохиолдолд Сангийн дотоод дүрэм, журам, хөрөнгийн хэмжээ, бүтэц зохион байгуулалт зэргийг тухайн үеийн хууль эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн өөрчилж ажиллана.

Нийгмийн болон улстөрийн эрсдэл: Нийгмийн эрсдэлд тухайн улс орны аливаа бизнесийн орчны өөрчлөлт (тухайлбал, мөнгөний бодлого, эрх зүй, зохицуулалтын өөрчлөлт, бослого жагсаал, иргэний дайн зэргийг оролцуулаад)-өөс хамааран тухайн улс оронд оруулсан хөрөнгө оруулалтын ашигт ажиллагаа эсхүл хөрөнгийн үнэ цэнэ өөрчлөгдөхийг хэлнэ. Улс төрийн эрсдэл нь аливаа улстөрийн шийдвэр, үйл явдал эсхүл нөхцөл байдлаас хамааран хөрөнгө оруулалтын ашигт ажиллагаа эсхүл хөрөнгийн үнэ цэнэ өөрчлөгдөхийг хэлнэ. Тиймээс нийгэм эдийн засаг, улстөрийн нөхцлийг цагтутам үнэлж тус эрсдэлээс сэргийлэн ажиллахыг зорино.

Татварын эрсдэл: Сангийн үйл ажиллагаатай холбоотой татварын бодлого, хууль журам өөрчлөгдөх болон тайлан бүртгэлтэй холбогдох эрсдэлүүд тус хэсэгт хамаарна. Татвартай холбогдох эрсдэлийн удирдлагын системийг хэрэгжүүлэх шалтгаан нөхцлийг нь тодорхойлох, сэргийлэх бууруулахад чиглэсэн тасралтгүй цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

Хүний нөөцийн эрсдэл: Хүний үйл ажиллагаанаас хамааран үйл ажиллагаанд санаандгүй эсхүл болгоомжгүй алдаа гарах болон мэргэжлийн ёс зүйн алдаа гарах зэрэг үйлдлүүд тус эрсдэлд багтана. Сан нь тус эрсдэлийг бууруулахын тулд ажилтнуудын мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлж байх, бодлого дүрэм журмаар дотоод хяналтын системийг бий болгон ажиллана. Хүний нөөцийн бодлого журмын хүрээнд сангийн зорилго, ёс суртахууны чиглэлд тохирсон хамгийн сайн мэргэжилтнүүдийг сонгож ажиллах бодлого баримтална.

Нэр хүндийн эрсдэл: Санхүүгийн бизнес нь итгэлцэлд суурилдаг тул хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, үнэт зүйлс, шударга байдал зэрэг нь нэн чухал зүйл юм. Хувь хүн ба хуулийн этгээдээс олон нийтэд болон зах зээлд Сантай холбоотой сөрөг, нэр хүндэд халдсан, худал мэдээлэл түгээх нь тус эрсдэлийг бий болгох магадлалтай. Тиймээс сангийн зүгээс үйл ажиллагааны үзүүлэлт, бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй тогтмол мэдээллэж байх, шударга, ёс зүйг эрхэмлэж ажиллахыг бүхий л бутцийн хувьд хэвшүүлэн ажиллана.

### 6.3 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРСДЭЛ

Сангийн нэгж эрх эзэмшигчдийн өгөөж, арилжааны идэвх болон үйл ажиллагаа зорилтот түвшнээс бага байх зэрэг эрсдэлүүд тус хэсэгт багтана.

Хөрөнгө оруулалтын эрсдэл: Сангийн нэгж эрх эзэмшигч нь санхүүгийн зах



оруулж буйн хувьд тодорхой эрсдэл хулээдэг. Тухайлбал Сангийн нэгж эрхийн үнэлгээ нэг тогтсон тувшинд байдаггүй, эдийн засаг, зах зээл болон хөрөнгө оруулалтын багцас шалтгаалсан олон хүчин зүйлсээс хамааран хэлбэлздэг. Сангийн хувьд багц нь Гадаад, дотоод эдийн засгийн нөхцлөөс шалтгаалан зарим жилд зорилтот өгөөжийн тувшинд хурч ажиллах боломжгүй үе мөн тохиож болно. Сан нь энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлж, зайлсхийх бүхий л судалгаа, шинжилгээг хийн, хөрөнгө оруулалтын багцыг зорилтот өндөр өгөөжтэй байлгахыг зорьж ажиллана.

**Нэгж эрхийн зах зээлийн ба цэвэр өнөөгийн үнэ цэнийн үнэлгээний эрсдэл:** Хөрөнгө оруулалтын итгэмжлэгдсэн сангийн хувьцаа буюу нэгж эрхийг худалдаж авсан хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын итгэмжлэгдсэн сангийн удирдлагын оруулсан хөрөнгийн эрсдэлээр эрсдэл хүлээнэ. Хөрөнгө оруулсан хөрөнгийн үнэ цэнэ цаг хугацааны явцад хэлбэлзэж болох учраас үндсэн төлбөр нь баталгаатай биш юм. Сангийн бодит үнэлгээ буюу нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэ цэнэ нь үйл ажиллагааны түвшнээс хамаарч тооцогдох бол зах зээл дээрх арилжигдах ханш нь хөрөнгө оруулагчдын эрэлт нийлүүлтээр тодорхойлогдоно. Тиймээс нэгж эрхийн дээрх хоёр үнэлгээ нь ялгаатай байж болох бөгөөд богино хугацааны хөрөнгө оруулагчдын хувьд тодорхой эрсдэл бий болгох магадлалтай.

**Ногдол ашгийн эрсдэл:** Сан нь үйл ажиллагааны үр дүнгээсээ хамааран хугацааны эцэст зорилтот ногдол ашгийг хуваарилах боломжгүй байх магадлалтай. Ногдол ашгийн бодлогод тусгасан ашгийн тодорхой хувийг нэгж эрх эзэмшигчиддээ хуваарилахын тулд сан нь зорилтот өгөөжийн тувшинд хурч ажиллахыг бүхий л талаар зорьж ажиллана.

**Хөрвөх чадварын эрсдэл:** Сан нь зөвхөн нэг удаа олон нийтэд санал болгох замаар хөрөнгө татан төвлөрүүлдэг бөгөөд мөн гаргасан нэгж эрхийг буцаан худалдан авах үүрэг хүлээдэггүй. Хэрэв нэгж эрх эзэмшигч нь хөрөнгө оруулалтаа эргүүлэн татах тохиолдолд "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-аар дамжуулан арилжаалах боломжтой. Энэ тохиолдолд эдийн засаг, санхуугийн зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан хөрвөх чадварын эрсдэл үүсэж болно. Сан нь үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй тайлагнан, зорилтот өгөөжийн тувшинд хурч тус эрсдэлийг бууруулж ажиллана.

ХАВСРАЛТ



Дараах баримт бичгүүдийг энэхүү нэгж эрхийн танилцуулгад хавсаргасан болно. Үүнд:

- (1) Сангийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- (2) хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг;
- (3) хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээний хуулбар, үйлчилгээний урамшуулал болон зардлын тооцоолол;
- (4) кастодиантай байгуулсан хөрөнгө хадгалах гэрээний хуулбар, үйлчилгээний хэлсний хэмжээ, тооцоолол;
- (5) Санг үүсгэн байгуулах ба римт бичгүүдийн батлагдсан эсхүл байгуулсан баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- (6) Сангийн нэгж эрхийн танилцуулгыг боловсруулахад оролцсон иргэн, хуулийн этгээдийн жагсаалт, тэдгээрийн үйлдсэн судалгаа, тайлан, дүгнэлт;
- (7) Сангийн санхүүгийн тайлан, түүний талаар аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт;
- (8) сүүлийн нэг жилээс дээшгүй хугацааны дотор хийлгэсэн хөрөнгийн үнэлгээний тайлан;

Миний бие, Ганбатын Ганзориг, нь дараах баталгааг үүгээр гаргаж байна. Үүнд:

“Биржид ирүүлж байгаа танилцуулга нь Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж байгаа танилцуулгатай адил, ямар нэг зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно.”

Г. Ганзориг

Нэр: Ганбатын Ганзориг

Албан тушаал: Сангийн менежер буюу гүйцэтгэх захирал



**Сангаас гарах нийт зардал****%**

<b>1</b>	Нийт үйлчилгээний зардлын хувь хэмжээ, жилээр	4% хуртэлх
<b>1.1</b>	Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээнд (Гүйцэтгэлээс хамаарч нэмэгдэх боломжтой)	1% (Гүйцэтгэлээс хамаарч нэмэгдэх боломжтой)
<b>1.2</b>	Хөрөнгө хадгалах үйлчилгээнд	0.2%
<b>1.3</b>	Багц бурдүүлтэнд /арилжааны шимтгэл, хураамж/	0.6% хуртэлх
<b>1.4</b>	Бусад /зар сурталчилгээ, аудит гэх мэт/ Нэгж эрх эзэмшигчдээс гарах зардал /хөрөнгө оруулалтын дүнгээс/	0.5% хуртэлх
<b>2</b>	Нэгж эрх худалдан авах, худалдахтай холбоотой зардал	Нэгж эрх эзэмшигч нь үйлчлүүлж буй үнэт цаасны компанийн тогтоосон арилжааны шимтгэлийг төлнө




МОНГОЛЫН ХЕРЕНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021 -06- 25

БҮРТГЭВ-03

СЗХ  
2021, 06 23 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01



MANDAL  
ASSET  
MANAGEMENT

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Жамъян-Гүний гудамж, Меру тауэр-602 тоот;  
**Утас:** 7272 9911  
**Имэйл:** support@mandalasset.mn  
**Вэбсайт:** mandalasset.mn

УЛААНБААТАР ХОТ  
МАНДАЛ  
ИРЭЭДҮЙН ӨСӨӨЛТ  
ХАМТЫН ХОС  
ХХК  
Г.Ганзориг

2021 -06- 25

НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГЫГ БАТАЛСАН:

СЗХ  
от 2021 06. 23  
вадар  
БҮРТГЭВ  
№ 01

Гарын үсэг:

Нэр:

Албан тушаал: “Мандал Ассет Менежмент УЦК” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Гарын үсэг:

Нэр:

Албан тушаал: “Мандал Ассет Менежмент УЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



ГЛАНЧААТАРЫН  
111835-11-111111

